

Техникийн дадлагажигч бэлтгэх ажил Аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээний тухай гарын авлага

ХАА-н ажлууд




Гарчиг

1	Техникийн дадлагажигч бэлтгэх хөтөлбөрийн тойм	
1	Удиртгал	1
2	Техникийн дадлагажигч бэлтгэх хөтөлбөрийн бүтэц	2
3	Хөдөө аж ахуй, ойн аж ахуйтай холбоотой ажил	3
4	Оршин суух зөвшөөрлийн карт	4
2	Аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх үндсэн ойлголт	6
3	Аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх.....	15
4	Хөдөө аж ахуйн машин техник ашиглахад аюулгүй	
	байдлыг хангах	19
5	Шат, эвхдэг шат зэрэг хэрэгслийг аюулгүй ашиглах	27
6	Малын саравч доторх аюулгүй байдал, эрүүл ахуй	29
7	Пестицидийг аюулгүй ашиглах	30
8	Наршилтаас сэргийлэх арга хэмжээ	31
9	Доод нуруу өвдөхөөс сэргийлэх арга хэмжээ	34
10	Шавжид хатгуулахаас сэргийлэх арга хэмжээ	35
11	Хүчил төрөгчийн дутагдлаас сэргийлэх арга хэмжээ	37
12	Техникийн дадлагажигчтай харилцаатай байхын ач	
	холбогдол	39
13	Эрүүл мэндийн үзлэг	40
14	Ажил дээр бэртэж гэмтэх тохиолдлууд	42

1 Удиртгал

Техникийн дадлагажигч бэлтгэх зөвшөөрөгдсөн хөтөлбөрүүдийн тоо хэмжээнд орсон өөрчлөлтүүд



(Эх сурвалж: Захиргааны статистик, Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллага)


Техникийн дадлагажигч бэлтгэх зөвшөөрөгдсөн хөтөлбөрүүдийн тоо хэмжээ өнгөрсөн жилүүдтэй харьцуулахад FY2020 (“financial year” буюу санхүүгийн жил) болон FY2021 онд эрс багассан нь COVID-19 цар тахалын халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээний улмаас Япон улсад зорчихыг хязгаарлсантай холбоотой юм. Япон улсад зорчих хязгаарлалт аажмаар суларсны дагуу дээрх тоо хэмжээ FY2022 оноос хойш нэмэгдсэн байгаа.

Нийт ажлуудын дотроос хөдөө аж ахуйтай холбоотой ажилд зөвшөөрсөн төлөвлөгөөний тоо хэмжээг харахад FY2019 онд буюу COVID-19 цар тахалын өмнө 32,419 тохиолдлууд байсан бол FY2023 онд 25,077 байсан нь нөхцөл байдал өнгөрсөнтэй харьцуулахад эс сайжирсан нь харагдаж байна. Гэсэн хэдий ч FY2023 онд хөдөө аж ахуйтай холбоотой ажлын тоо хэмжээ нь нийт зөвшөөрсөн төлөвлөгөөнүүдийн 7.2%-ийг эзэлжээ.

Хөдөө аж ахуйн ажилд бэлтгэл сургалт явуулдаг байгууллагуудын дийлэнх нь хяналтын төрлийн байгууллагууд бөгөөд техникийн дадлагажигч бэлтгэх сургалтыг хувиараа бизнес эрхлэгч байгууллагууд ихэвчлэн явуулдаг. Гэсэн хэдий ч хувиараа бизнес эрхлэгч байгууллагууд нь аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай мэдлэг бүхий мэргэжилтнүүдгүйн улмаас аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээг бүрэн гүйцэт хэрэгжүүлэх боломжгүй байх нь бий.

Тус гарын авлага нь хөдөө аж ахуйн ажилд тусгайлан зориулсан аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээний үндэс суурийг бүрэлдүүлэх их хэмжээний мэдээллийг цуглуулсан болно. Тус гарын авлагыг 9 хэлээр бэлтгэн нийтлэх болсон нь хамаа бүхий байгууллагууд эдгээр мэдээллийг техникийн дадлагажигч бэлтгэх үйл ажиллагаандаа зааварчилгаа болгон ашиглах боломжтой юм.

Тус гарын авлагыг ашигласанаар техникийн дадлагажигч бэлтгэх үйл ажиллагаанд оролцогч хэн бүхэнд аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээг сайжруулах тал дээр тус дэм болно гэдэгт бид найдаж байна.



Одоогийн байдлаар Техникийн дадлагажигч бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд 91 ажлын ангилал, 167 үйл ажиллагааг техникийн дадлагажигч бэлтгэх ажилд (ii) хамааруулах боломжтой гэж заасан байдаг. Үүнд хөдөө аж ахуйн, ойн аж ахуйн чиглэлээр дараах 3 ажлын ангилал, 7 үйл ажиллагааг явуулахаар болов. Ажлын ангилал болон үйл ажиллагаа бүрт техникийн дадлагажигчдын хийх ёстой үүрэг даалгаврыг тогтоосон бөгөөд эдгээр нь (i)-ээс (iii) дахь үе шатад техникийн дадлагажигчдын бэлтгэлийн хугацааны хамгийн багадаа 50%-г эзлэх юм.

Хөдөө аж ахуй, ойн аж ахуйн ажлууд (2024 оны 9-р сарын 30-ны байдлаар 3 ажлын төрөл, 7 үйл ажиллагаа багтсан)

Ангилал	Үйл ажиллагаа
Газар тариалан	Ногоон хүлэмж
	Уулархаг тариалан газар/ногоо ургуулалт
	Жимс жимсгэнэ
Мал сүрэг	Гахайн ферм
	Тахианы ферм (тахианы өндөг хураалт)
	Сүү, цагаан идээ
Ойн аж ахуй	Ойжуулалт

*Ойн аж ахуйн ажлуудыг 2024 оны 9 -р сарын 30-наас нэмж оруулсан.

Тус гарын авлагад газар тариалан, мал аж ахуйг хөдөө аж ахуйн ажил хэмээн тодорхойлов.

Техникийн ур чадварын тест, үнэлгээ

Тусгай мэргэжлийн ур чадварын тест ба үнэлгээ нь Техникийн дадлагажигч бэлтгэх хөтөлбөрт заасан ажлын төрөл бүрт техникийн дадлагажигчдын эзэмшсэн ур чадварыг үнэлэх зорилготой юм. Техникийн дадлагажигчид нь (i) (ii) дараа нь (iii)-р үе шатад шилжихийн тулд зохих шалгалтыг өгч, тэнцсэн байх ёстой. Тиймээс техникийн дадлагажигчдад сурч буй үе шатад нь нийцсэн ур чадварыг өгөхийн тулд хүлээн авсан үүрэг даалгаварт нь тохирсон зааварчилааг өдөр тутам өгч байх ёстой.

Техникийн дадлагажигч бэлтгэх хөтөлбөр дэх тусгай мэргэжлийн ур чадварын тест нь үндсэн, 3 -р түвшин, 2 -р түвшин, ахицтай түвшин гэсэн түвшинтэй.

Тестийг ур чадвар дээшлүүлэх байгууллага явуулна. Хяналт ба зохион байгуулалтын төрлийн сургалт хийх бол хяналтын байгууллагууд нь Техникийн дадлагажигч бэлтгэх байгууллагын өгсөн Тестийн журмын талаарх мэдээллийн вэб сайт руу орж тест авах хүсэлт гаргах шаардлагатай (<https://www.juken.otit.go.jp/>) (зөвхөн япон хувилбар).

* Хөдөө аж ахуйн ажлын хүрээнд техникийн дадлагажигчид Үндэсний хөдөө аж ахуйн танхимаас хэрэгжүүлж буй хөдөө аж ахуйн ур чадварын үнэлгээний шалгалт өгөх ёстой. Тестийн түвшин болон дүйцэх мэргэшлийг доор жагсаав.

Түвшин	Үйл ажиллагаа	Тестийн дэлгэрэнгүй
Анхан шатны түвшин	6 болон үүнээс дээш сарын практик туршлагатай дадлагажигч	Үндсэн ажил гүйцэтгэхэд шаардлагатай үндсэн мэдлэг, ур чадвар
Дунд шатны түвшин	12 болон үүнээс дээш сарын практик туршлагатай дадлагажигч	Үндсэн ажил гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар
Мэргэжлийн түвшин	24 болон үүнээс дээш сарын практик туршлагатай дадлагажигч	Анхан шатны түвшний фермерүүдийн эзэмшдэг мэдлэг, ур чадвар
Ахицтай түвшин	48 болон үүнээс дээш сарын практик туршлагатай дадлагажигч	Ерөнхий фермерүүдийн эзэмшдэг мэдлэг, ур чадвар

Тусгай мэргэжлийн ур чадварын тест болон үнэлгээ хийхэд шаардагдах төлбөрийг “техникийн дадлагажигч бэлтгэх, хамгаалах үндсэн бодлого (Хууль зүйн яам, Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн халамжийн тухай 2017 оны 1-р мэдэгдэл)”-д заасны дагуу хэрэгжүүлэгч байгууллага, эсхүл хяналтын байгууллага төлнө (зөвхөн япон хувилбар).


4 Оршин суух зөвшөөрлийн карт

Цагаачлагч, дүрвэгсдийг хянах, хүлээн авах тухай хуулийн 23 дугаар зүйлд (Засгийн газрын 1951 оны 319 тоот тушаал, цаашид “Цагаачлалын хяналтын тухай хууль” гэх) заасны дагуу дунд, урт хугацаагаар оршин суух эрхтэй техникийн дадлагажигчид картаа биедээ байнга авч явах шаардлагатай.

Техникийн дадлагажигч бэлтгэх, хамгаалах үндсэн бодлогын 48-р зүйлд заасны дагуу хяналтын байгууллага ба хэрэгжүүлэгч байгууллага оршин суух зөвшөөрлийн картыг хадгалахыг хориглоно.

* Хяналтын байгууллага оршин суух зөвшөөрлийн картыг оршин суух статус өөрчлөх зэрэг хууль ёсны журмын дагуу түр зуур хадгалж болно. Гэхдээ хадгалсан картыг аль болох түргэн буцааж өгөх шаардлагатай.

Мөн ажилтан дадлагажигчид оршин суух зөвшөөрлийн картыг нь хүлээлгэн өгсөн эсвэл авсан гэсэн тодорхой баримт шаардлагатай.



住居地 (Оршин суудаг газар)

Аливаа өөрчлөлтийг картын ар талд тодорхойлсон байгаа.

就労制限の有無 (Ажлын хязгаарлалт)

Техникийн дадлагажигч бэлтгэх үйл ажиллагаанаас өөр бусад ажил хийж болохгүй.

在留期間 (満了日) (Оршин суух хугацаа (хугацаа дуусах огноо))

Дадлагажигчийн япон улсад оршин суух хугацааг заана.

有効期間 (Хүчинтэй хугацаа)

Оршин суух зөвшөөрлийн картын хүчинтэй хугацаа.

資格外活動許可欄

(Оршин суух статуст тодорхойлсноос өөр бусад ажил хийх зөвшөөрөл)

Техникийн дадлагажигчид оршин суух зөвшөөрлийн карт дээр нь тодорхойлсноос өөр бусад ажил хийх боломжгүй.

► Оршин суух зөвшөөрлийн картыг хэрхэн зөв унших талаарх дэлгэрэнгүй мэдэллийг Цагаачлалын албаны вэб сайтын “Оршин суух зөвшөөрлийн карт гэж юу вэ” хэсгээс харна уу (зөвхөн япон хувилбар).

https://www.moj.go.jp/isa/applications/faq/newimmiact_4_point.html#anchor-point 1



Оршин суух зөвшөөрлийн картын хүчинтэй хугацааг шалгах боломжтой.

Оршин суух зөвшөөрлийн картын хугацаа дууссан эсэхийг шалгахын тулд Цагаачлалын албаны вэб сайт руу орж “Оршин суух зөвшөөрлийн картын дугаарын дуусах хугацааг лавлах” талбар дээр (зөвхөн япон хувилбар) дараад оршин суух зөвшөөрлийн картын дугаараа оруулна уу. <https://lapse-immi.moj.go.jp/ZEC/appl/e0/ZEC2/pages/FZECST011.aspx>

Хүчинтэй хугацаа нь картын урд талд зааснаас өөрж байж болно.

Хүчинтэй хугацааг оршин суух картын нүүрэн талд заасан байдаг. Гэхдээ оршин суух статусаа өөрчлөх, эсвэл оршин суух хугацаагаа сунгах хүсэлтийг картын нүүрэн талд заасан оршин суух хугацаа дуусахаас өмнө гаргасан бол үүнийг оршин суух картын ард заасан байдаг бөгөөд картын нүүрэн тал дахь оршин суух хугацаа дууссан өдрөөс хойш 2 сарын хугацаанд хүчинтэй байна.

Анхаар

Хэрэв хэрэгжүүлэгч байгууллага нь техникийн дадлагажигчийг өөр нэгэн хэрэгжүүлэгч байгууллагад (хувь хүнд эсвэл албан байгууллагад) цагаар ажиллуулах, эсвэл ажил хийх зөвшөөрөлгүй гадаад иргэнийг эсвэл оршин суух зөвшөөрлийн карт дээр нь зааснаас өөр бусад ажил хийх зөвшөөрөлгүй ажилчныг ажиллуулбал хууль бусаар хөдөлмөр сурталчлах гэмт хэрэгт буруутгагдаж болзошгүй (Цагаачлалын хяналтын тухай хуулийн 73-р зүйл 2-р хэсэг). Гадаадын иргэний оршин суух статусыг шалгах шаардлагатай бол дүүргийнхээ цагаачлалын албад хандана уу.

Аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх үндсэн ойлголт

*Тус гарын авлагад Аж үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль (1972 оны 57-р хууль)-ийг "Аж үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль" гэж, "Аж үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай тогтоол" (Хөдөлмөрийн яамны 1972 оны 32 дугаар тогтоол)-ыг "Аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай тогтоол" гэж тус тус заасан болно.

Аж үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль

① Ажилд элсүүлэхэд явагдуулах сургалт 59-р зүйл, (1) дэх хэсэг

② Ажлын төрөлд өөрчлөлт орсон үед явагдуулах сургалт 59-р зүйл, (2) дэх хэсэг

③ Тусгай сургалт 59-р зүйл, (3) дахь хэсэг

Ахлах ажилчны сургалт 60-р зүйл

Аюул, эрсдэлтэй нөхцөлд ажилладаг ажилчдын сургалт 60-р зүйл, 2 дахь хэсэг

Техникийн дадлагажигчдад зориулсан аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт

Техникийн дадлагажигчдыг аюулгүй байдал, эрүүл ахуйн тал дээр илүү сайн ойлголттой болгох, тэднийг онцгой нөхцөл байдалд шуурхай арга хэмжээ авахуулахын үүднээс япон хэлийг аль болох хялбарчлан зааж өгөх, мөн ойлгоход хялбар дүрслэл, видео ашиглана.



Ажилд элсүүлэхэд болон ажлын төрөлд өөрчлөлт ороход явагдуулах аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт

(Аж үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн (1), (2) дахь хэсэг)

Техникийн шинэ дадлагажигчдыг (ажилчид) элсүүлэх болон ажлын төрөлд өөрчлөлт ороход дараах асуудлаар аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг нэн дариу явагдуулна.

- ① Машин техник, түүхий эдтэй харьцахад тохиолдож болох аюул, эрсдэл, болон эдгээртэй хэрхэн зөв харьцах тухай
- ② Аюулгүй байдлын тоног төхөөрөмж, хорт бодис хянах тоног төхөөрөмж, хамгаалалтын хэрэгслийн гүйцэтгэлийн талаарх асуудал, мөн эдгээртэй хэрхэн зөв харьцах
- ③ Ажлын журамтай холбоотой асуудлууд
- ④ Ажил эхлэхэд хийх үзлэгтэй холбоотой асуудлууд
- ⑤ Тухайн ажлыг гүйцэтгэх үед тохиолдож болох өвчлөлийн шалтгаан болон өвчлөлөөс урьдчилан сэргийлэхтэй холбоотой асуудлууд
- ⑥ Seiri (ялгаж салгах), Seiton (эмхлэн цэгцлэх) болон Seiketsu (жигдрүүлэх)-г сахихтай холбоотой асуудлууд
- ⑦ Осол гарсан үед авах онцгой арга хэмжээ болон нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой асуудлууд
- ⑧ Дээр дурдсан зүйлсээс гадна ажлын байран дахь аюулгүй байдал, эрүүл ахуйд шаардлагатай өөр бусад асуудлууд

Тусгай сургалт

(Аж үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн (3) дахь хэсэг (Аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай тогтоолын 36 дүгээр зүйл))

Техникийн дадлагажигчдад (ажилчид) аюул, эрсдэлтэй ажил даалган өгсөн бол тэднийг эрүүл ахуй, аюулгүй байдлын тусгай сургалтад хамрагдуулах шаардлагатай. Сургалтыг засаг захиргааны нэгжид бүртгэлтэй сургалтын тусгай агентлагууд явуулна.

Хэрэв байгууллагад тухайн ажил үүрэгт хангалттай мэдлэг, ур чадвар бүхий хүн байгаа бол сургагчаар томилон сургалтыг дотооддоо явагдуулах боломжтой.

Тусгай сургалт шаардах ажлуудаас энд хөдөө аж ахуйтай холбоотой ажлуудыг загсаав.

Дэлгэрэнгүй мэдээллийг Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр ба нийгмийн халамжийн вэб сайт дахь “Лиценз, мэргэшил, ур чадвар дээшлүүлэх сургалт, аж үйлдвэрийн аюулгүй байдал ба эрүүл ахуйн тусгай сургалт” хэсгээс харна уу (зөвхөн япон хувилбар) (https://www.mhlw.go.jp/stf/seisakunitsuite/bunya/roudoukijun/anzenisei10/qualification_education.html).

[Босоо мод унагах, унжсан модыг хаях, хугалах зэрэгт цахилгаан хөрөө ашиглан ажил хийх]



[Даацын дээд хэмжээ 1 тонноос үл хэтрэх сэрээт өргөгч ажиллуулах ажил]

[Даацын дээд хэмжээ 1 тонноос үл хэтрэх хүрээт ачигч, сэрээт ачигч ажиллуулах ажил]

[Даацын дээд хэмжээ 1 тонноос үл хэтрэх бартаат замын тээврийн хэрэгсэл ажиллуулах ажил]

[Газар шорооны ажил хийх машин техник ажиллуулах (газар тэгшлэх машин зэрэг)]




Бульдозер, драглайн экскаватор, хүрээт малтагч, хусагч дозер, ардаа хутгаж ачигч машин зэрэг 3 тонноос* бага жинтэй тээврийн хэрэгслийн жижиг оврын газар шорооны машин (газар тэгшлэх, тээвэрлэх, ачих, ухах зориулалттай) ажиллуулах ажил

*Ур чадвар дээшлүүлэх сургалтад хамрагдаагүй дадлагажигчид 3 тонн буюу үүнээс илүү жинтэй машин ажиллуулж үл болно.

[5 тонноос бага жин өргөх хүчин чадалтай кран ажиллуулах ажил]

[1 тонноос бага жин өргөх хүчин чадалтай зөөврийн кран ажиллуулах ажил]

1 тонноос бага өргөх хүчин чадалтай кран буюу зөөврийн кран дээр ажиллах




[Барилгын шат угсрах, буулгах, өөрчлөх ажил]

- “Барилгын шат” гэх нэр томъёод бас дугуйтай барилгын шат багтсан.
- * Барилгын шатны төрөл болон тэдгээрийн өндөрлөгт хязгаарлалт байдаггүй учраас, бэхлүүр болон тавцанг дүрслэн зурагт заасны дагуу нэгж болгон угсран ажиллах бол дадлагажигчид тусгай сургалтад орсон байх шаардлагатай.



[Хүчил төрөгч багатай орчинд ажиллах үед үүсч болох аюул]

Сило зэрэг хүчил төрөгчийн концентрац багатай битүү орчинд ажиллах



[Бут сөөгийн анжис дээр ажилладаг хүмүүст зориулсан аюулгүй байдлын сургалт*]

Бут сөөгийн анжис ашиглан ажилладаг хүмүүс

- * Энэ нь Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр ба нийгмийн халамжийн мэдэгдэлд үндэслэсэн “Бут сөөгийн анжис дээр ажиллагчдын аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт (2000 оны 2-р сарын 16-ны өдрийн 66 дугаар мэдэгдэл)” (зөвхөн япон хувилбар)-д үндэслэсэн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт (тусгай боловсролын шаардлагад нийцсэн сургалт) болно



Тусгай ажлууд

(Аж үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 61 дүгээр зүйл)

Техникийн дадлагажигч тусгай ажил (Аж үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд аюул хөнөөлтэй хэмээн тодорхойлсон) хийх бол ур чадварын сургалтад явсан байх шаардлагатай.

Дадлагажигчид ур чадварын сургалт гүйцэтгэх шаардлагатай ажлуудаас энд хөдөө аж ахуйтай холбоотой ажлуудыг загсаав.

[Сэрээт өргөгч]

Хамгийн ихдээ 1 тонн ба үүнээс илүү даацтай сэрээт өргөгч ажиллуулах ажил



[Газар шорооны ажил хийх машин техник ажиллуулах (газар тэгшлэх машин зэрэг)]

Бульдозер, драглайн экскаватор, хүрээт малтагч, хусагч дозер, ардаа хутгаж ачигч машин зэрэг 3 тон ба үүнээс илүү жинтэй газар шорооны машин (газар тэгшлэх, тээвэрлэх, ачих, ухах зориулалттай) ажиллуулах ажил


[Хүрээт ачигч]

Хамгийн ихдээ 1 тонн ба үүнээс илүү даацтай хүрээт ачигч, сэрээт ачигч ажиллуулах ажил




[Бартаат замын тээврийн хэрэгсэл]

Хамгийн ихдээ 1 тонн ба үүнээс илүү даацтай бартаат замын тээврийн хэрэгсэл ажиллуулах ажил



[Жижиг оврын зөөврийн кран]

1 тонноос 5 тонн хүртэл өргөх хүчин чадалтай зөөврийн кран



Дараах ажлуудыг хийхэд нэг хүнийг даргаар томилох бөгөөд тэрээр лиценз авсан байх эсвэл ур чадварын сургалт гүйцэтгэсэн байх шаардлагатай.

* Даргыг Аж үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу ажил дээрх бэртэл гэмтлээс урьдчилан сэргийлэхийг шаардсан зарим ажлын ангилалд багтсан ажил үүргийг даргалахаар томилсон байх шаардлагатай.

Энд голдуу хөдөө аж ахуйтай холбоотой ажлуудыг загсаав.

[Бараа ачилтын дарга]

2 метр ба үүнээс өндрөөс бараа ачих (давхарлан өрөх*) бараа буулгах ажил (бараа ачих машин ашиглан хийсэн ажил үл орно).

* Бараа гэдэг нь агуулахад тавцан дээр эсвэл шалан дээр өрсөн барааг хэлнэ. Ачаа гэдэг нэр дор уут, хайрцаг, бухал өвс, модны үртэс зэрэг орж болно.

[Хүчил төрөгч багатай орчинд ажиллахад заавал байх мэргэжилтэн]

Сило зэрэг хүчил төрөгчийн концентрац багатай битүү орчинд ажиллах бол тусгай мэргэжилтэн томилогдон даргалан ажиллах шаардлагатай.

Тус мэргэжилтэн нь хүчил төрөгч багатай нөхцөл болон устөрөгчийн сульфидтай нөхцөлд ажиллах тал дээр тусгай сургалтад хамрагдаж зохих ур чадварыг эзэмшсэн байх шаардлагатай.




Ажлын хувцас толгооны хамгаалалт хэрэглэх

Зориулалтын хувцас өмсөх нь газар тариалангийн ажил хийх явцад бэртэж гэмтэхээс сэргийлэх аюулгүй байдлын эхний алхам юм.

Зориулалтын хувцас өмсөх нь тухгүй байж болох боловч ажлыг илүү үр бүтээмжтэй болгох юм. Тиймээс техникийн дадлагажигчдын хийх ажлын төрөлд нийцсэн хамгаалалтын хэрэгслийг сонгоно уу.

* Өргөст ургамал, хорхой шавжид хатгуулахаас хамгаалахын тулд урт ханцуйтай өмд, цамц (футболк, шорт биш) өмс.



[Хамгаалалтын малгай]

Өндөрт ажиллах, дээрээс юм унах эрсдэлтэй, замын дагуу зорчих шаардлагатай нөхцөлд дуулга буюу хамгаалалтын малгай өмс.

Дуулганы эрүүний бүч чанга эсэхийг шалга.



[Бээлий]

Хурц ирмэгтэй зүйлстэй харьцах бол хамгаалалтын бээлий заавал өмс.



[Хамгаалалтын шил (нүдний шил)]


Пестицид шүрших ба холих үед, үсэрсэн модны хэлтэрхий, гагнуурын хурц гэрэл зэргээс нүдний шил зүүж нүдээ хамгаал.



[Өндрөөс унахаас хамгаалах хэрэгсэл (хамгаалалтын тоноглол)]

Өндөрлөгт ажиллах үед өндрөөс унахаас сэргийлэн хамгаалалтын тоноглол ашигла.

(Зурагт бүрэн тоноглолыг харуулав)



[Чихний бөглөө]

Чанга дуу чимээтэй орчинд ажиллах бол чихний бөглөө ашигла.

Чихний бөглөө эсвэл дуу намсгагч чихэвч (чихний гадуур зүүдэг) байж болно.



[Хамгаалалтын гутал]

Дээрээс хүнд зүйлс унаж болзошгүй, хадаас зэрэг хурц зүйл дээр гишгэх эрсдэлтэй орчинд ажиллах бол хатуу хоншоортой, халтирдаггүй гутал өмс.



[Тоосны маск, хорт хийн маск]

Тоос, тоосонцор ихтэй орчинд ажиллах бол “тоосны маск”, хүчил төрөгч багатай орчинд ажиллах бол “хүчил төрөгчийн маск” зүү. Мөн пестицид цацахад хийнээс хамгаалдаг цахилгаан сэнс суурилуулсан хийн маск эсвэл амьсгалын замын хамгаалалтын хэрэгслэл ашиглана уу.



Аюулгүй байдлын тэмдэг

Аюулгүй байдлын тэмдгүүд нь ажлын байранд бэртэж гэмтэхээс урьдчилан сэргийлэх зорилготой юм. Эдгээр нь аюултай ажил хийх, аюултай бүсэд нэвтрэх тухайд ажилчдад анхааруулдаг бөгөөд тэднийг аюулгүй ажиллагааны шаардлагад нийцүүлдэг.

Аюулгүй байдлын тэмдгүүдийг хүн бүрт ойлгомжтой байлгахын үүднээс Олон улсын ISO 7010:2019 стандарт (График тэмдэг - Аюулгүй байдлын өнгөт тэмдэг, пайз - Бүртгэгдсэн албан ёсны тэмдэг зэрэг) болон Японы аж үйлдвэрлэлийн JIS Z 8210:2017 стандартын дагуу ашиглана уу.

Үүнээс гадна Японы барилгын аюулгүй байдал, эрүүл ахуйн байгууллага (JCOSHA)-аас тогтоосон "Барилгын ослоос урьдчилан сэргийлэх нэгдсэн аюулгүй байдлын тэмдэг"-ийг доор оруулав.

Эдгээр аюулгүй байдлын тэмдгүүдийг үнэ төлбөргүй ашиглах боломжтой. Тайлбарыг пиктограммын доорх хоосон цагаан талбайд дадлагажигчийн эх хэлээр (доорх жишээнд монгол хэл ашиглав) оруулна уу. Хэрхэн ашиглах талаар дэлгэрэнгүй мэдээллийг JCOSHA вэб сайт дахь "Барилгын ослоос урьдчилан сэргийлэх аюулгүй байдлын нэгдсэн тэмдгүүдийн заавар" хуудсаас (зөвхөн япон хувилбар) авна уу. https://www.kensaibou.or.jp/safety_sign/index.html



Аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх

5S-ийг хэрэгжүүлэх нь

5S гэдэг нь Seiri (ялгаж салгах), Seiton (эмхлэн цэгцлэх), Seisou (цэвэрлэх), Seiketsu (жигдрүүлэх) ба Shitsuke (тогтворжуулах) хэмээх 5 үгийн эхний 5 үсэг болно. 5S-ийг өдөр тутам биелүүлэх нь ажлын байранд бэртэж гэмтэхээс урьдчилан сэргийлэхэд чухал юм.


	Тайлбар	Жишээ	Хариу арга хэмжээ
[Seiri (ялгаж салгах)] 	Seiri (ялгаж салгах) гэдэг нь хэрэггүй зүйлсийг хэрэгтэй зүйлсээс ялгаж салгахыг хэлнэ.	Жишээлбэл хэрэггүй эд зүйлсийг үүд, горидорт орхих нь ажилчдыг бүдэрч унагаахаас гадна ажлын үр бүтээмжийг бууруулах нь бий.	Тиймээс хэрэггүй зүйлсийг ялгаж салгах процедур гаргана уу.
[Seiton (эмхлэн цэгцлэх)] 	Seiton (эмхлэн цэгцлэх) гэдэг нь ажлын багаж хэрэгслийг ашиглахад бэлэн байлгахад хэрхэн, хаана тавихыг хэлнэ.	Багаж хэрэгслийг эмх замбараагүй орхих нь ажилчид хэрэгтэй багаж хэрэгслээ олохгүй хайсаар цаг хугацаа дэмий өнгөрөх нь бий.	Тиймээс ажлаа хийж дууссан бол багаж хэрэгслийг байранд нь тавина уу.
[Seisou (цэвэрлэх)] 	Seisou (цэвэрлэх) гэдэг нь машин техник, тоног төхөөрөмж, агуулах, ажлын байрыг хог новшоос ангид байлгаж хувцас хунараа цэвэрлэхийг хэлнэ.	Хог новш, тоос шороо зэргийг цэвэрлэхгүй үлдээх нь ажилчид таварцаглаж, унаж бэртэх эрсдэлтэй юм.	Тиймээс ажил хийж дууссаны дараа ажлын байрыг өдөрт нэг удаа цэвэрлэж, хувцас хунараа угаана уу.
[Seiketsu (жигдрүүлэх)] 	Seiketsu (жигдрүүлэх) гэдэг нь seiri, seiton ба seisou-г сайн түвшинд хүргэж бие махбод, хувцас хунар, орчин тойрноо цэвэрхэн байлгахыг хэлнэ.	Агуулах дахь жимс ногооны үлдэгдлийг цэвэрлэхгүй үлдээх нь эрүүл ахуйн асуудал үүсгэж болзошгүй юм.	Тиймээс ажлын байрын хэвийн байдлыг хангах стандартжуулсан системийг хэрэгжүүлэхийг зөвлөж байна.
[Shitsuke (тогтворжуулах)] 	Shitsuke (тогтворжуулах) гэдэг нь Seiri (ялгаж салгах), Seiton (эмхлэн цэгцлэх), Seisou (цэвэрлэх) ба Seiketsu (жигдрүүлэх) буюу 4 S-ийг бүрэн хэрэгжүүлэх дүрэм журам, зөв дадлыг гаргахыг хэлнэ.	Байнгын сургалт, зааварчилгаа явуулахгүй бол тогтоосон дүрэм журмыг бүрэн гүйцэт сахихгүй байх эрсдэлтэй юм.	Ажилчин бүр тогтоосон дүрэм журмыг дагахыг хичээх ёстой.

Аюулгүй байдлыг хангахын тулд 5 S-ийг хэрэгжүүлнэ үү

[Хадгалах тухайд анхаарах зүйлс]

① Эд зүйлсийг хадгалж үл болох газрууд

- Горидор, үүд хаалга, яаралтай гарц, шатыг эд зүйлсээс ангид байлга.




- Машин техник, хяналтын самбар, галын гидрант, гал унтраагчийг эд зүйлсээс ангид байлга.




② Зориулалтын орон зай, хадгалах горим

- Газар тариалангийн машин, тоног төхөөрөмжийг тусгайлан байрлуулах орон зайг гаргаж, эдгээрийг горимын дагуу зөв байрлалд байрлуул. Орон зай дахь гэрэлтүүлэг, агааржуулалтыг зохих түвшинд байлга.
- Тоног төхөөрөмжийг хэрхэн байрлуулах, хадгалах дүрмийг ягштал баримтал.



③ Хэлбэр дүрсэд нийцүүлэн байрлуул


- Урт тоног төхөөрөмжийг хэвтээгээр нь, хананд налуулахгүйгээр, өнхөрдөг бөөрөнхий зүйлсийг шаантаг зэрэг тогтоох зүйлээр бэхэлж байрлуул.



- Урт зүйлсийг хананд налуулан байрлуулахдаа унахаас сэргийлэн олсоор уяж бэхлэх шаардлагатай.




- Хүрзийг хананаас өлгөх эсвэл бэхлэх шаардлагатай.




④ Ойр ойрхон хэрэглэдэг зүйлс

- Ойр ойрхон хэрэглэдэг зүйлсийг авч хэрэглэхэд амархан газар байрлуул.



⑤ Хурц ирмэгтэй зүйлс

- Хурц ирмэгтэй зүйлсийг хучиж байрлуул.



Эрсдлээс урьдчилан сэргийлэлт (KY арга хэмжээ), ажлын өмнөх уулзалт (TBM)

[KY арга хэмжээ]

Эрсдлээс урьдчилан сэргийлэх (K: Kiken, Y: Yochi) арга хэмжээ гэдэг нь ажлын байранд бэртэж гэмтэхээс урьдчилан сэргийлэх зорилготой юм. Ажилчид илүү сонор сэрэмжтэй ажиллахын тулд эрсдэл, бэртэл гэмтлийн талаар ярилцаж санаа бодлоо хуваалцдаг. Энэ арга хэмжээг “KYK” (Kiken Yochi Katsudou) гэнэ.

[TBM]

Өдөр бүр ажил эхлэхийн өмнө тухайн өдөр хийх ажлын талаар ярилцаж, ямар аюулаас болгоомжлох тухайд дэлгэрэнгүй мэдээлэл өгнө. Tool box meeting (TBM) буюу ажлын өмнөх уулзалт гэдэг нь ажилчид ажил эхлэхийн өмнө уулзаж “ямар ажил” хийх талаар ярилцаж, болзошгүй аюулын талаар санал бодлоо солилцохыг хэлнэ.

“Аюултай нөхцөл байдал” ба “аюултай үйлдэл” гэх 2 хүчин зүйлс нэгэн зэрэг илрэхэд осол гардаг. Тиймээс болгоомжгүй, болчимгүй авирлахгүйн тулд “аюултай үйлдэл” гаргахгүй байх нь чухал юм.




Хөдөө аж ахуйн машин техник ашиглахад аюулгүй байдлыг хангах

Хөдөө аж ахуйн салбарт тохиолдсон осол

Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуурын яамнаас гаргасан нийтлэлээс харахад хөдөө аж ахуйн салбарт тохиолдсон эндэгдэл (2022 оны байдлаар 100 мянган ажилчин дундаас нас баралтын тоог харахад) бусад салбаруудын дундажтай харьцуулахад 9 дахин илүү байсныг доорх график 1-д харуулав.

Осолд нас барагсдын (238 хүн) эндсэн шалтгааныг задлан авч үзэхэд 62 хүн тракторт, 21 хүн түрдэг тракторт, 16 хүн газар тариалангийн тээврийн хэрэгсэлд тус тус эндсэн нь нийт хэмжээний 41.6% эзэлсэн байна (график 2-т харуулав). Бүт сөөгийн анжис зэрэг газар тариалангийн машин техникээс үүдсэн эндэгдлийг тооцвол дээрх тоо баримт 63.9% болтлоо өсөх юм.

График 1 : 100 мянган ажилчин дундаас нас барагсдын тоонд орсон өөрчлөлт



Эндэгдлийн тоо хэмжээний талаарх мэдээллийн эх сурвалж

Хөдөө аж ахуй:

Хөдөө аж ахуйн ажил дээрх нас баралтын судалгаа (зөвхөн япон хувилбар) (Хөдөө аж ахуй, Ойн аж ахуй, Загас агнуурын яам)

Бусад салбарууд:

Ажил дээрх нас баралт (зөвхөн япон хувилбар) (Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр ба нийгмийн халамж)

Ажилчдын тоо хэмжээний талаарх мэдээллийн эх сурвалж

Хөдөө аж ахуй:

Хөдөө аж ахуй, ойн аж ахуйн тооллого, Хөдөө аж ахуйн бүтцийн хөдөлгөөний тухай судалгаа (Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуурын яам)

Бусад салбарууд:

Ажиллах хүчний тухай судалгаа (Дотоод хэрэг, харилцаа холбооны яам)

График 2 : Эндэгдлийг шалтгаанаар нь харуулсан нь (2022)

Машин механизм, байгууламжаас


бусад осол
81 хүн (34.0%)

Мод гэх мэтэд өндрөөс унасан
7 хүн (2.9%)

Үрслүүлсэн газар, эсвэл зам дээр
өндрөөс унасан
12 хүн (5.0%)

Будааны сүрэл шатаах
явцад түлэгдсэн
15 хүн (6.3%)

ХАА-н байгууламжийн
ажилтай холбоотой осол
5 хүн (2.1%)




Эх сурвалж: Газар тариалан, Хөдөө аж ахуй, Ойн аж ахуй, Загас агнуурын яамнаас нийтэлсэн баримт бичгүүд, 2024 оны 2-р сарын 22-ний өдөр
<https://www.maff.go.jp/j/press/nousan/sizai/240222.html>

Техникийн дадлагажигч бэлтгэх арга хэмжээнүүд

- ① Техникийн дадлагажигч бэлтгэх хүрээнд хэрэгжүүлэгч байгууллагууд нь техникийн дадлагажигчдынхаа чадварын түвшинг мэддэг байх, ямар дадлагажигч ямар машин техник, тоног төхөөрөмжийг ашиглаж болох тал дээр, мөн техникийн дадлагажигч бэлтгэх хөтөлбөрийн дагуу эдгээрийг ашиглахад шаардагдах мэдлэг, ур чадварыг эзэмших тухайд бүхий л мэдэллийг өгөх ёстой.

Машин техниктэй харьцахдаа удирдагч, сургагч нар дадлагажигчдын аюулгүй ажиллах нөхцлийг хангахын үүднээс тэдэнд зөвлөгөө, зааварчилгаа өгөх ёстой. Дадлагажигчдыг эрсдэл багатай машин техник дээр ажиллуулж эхлэх нь бас үр дүнтэй байдаг. Жишээлбэл, ажлын арга барилтай хараахан танилцаж амжаагүй дадлагажигчдыг нейлон дугуй хөрөө бүхий бут сөөгийн анжис дээр ажиллуулах нь эрсдэл багатай юм.



Нейлон дугуй хөрөө

- ② Дадлагажигчид газар тариалангийн машин техник дээр ажиллахын өмнө лиценз буюу тусгай зөвшөөрөл авсан байх шаардлагатай.

Жишээлбэл, зам тээвэрт трактор, комбайн, сэрээт өргөгч зэрэг газар тариалангийн машин техник жолоодоход Замын хөдөлгөөний тухай хуульд заасны дагуу жолооны үнэмлэх (жижиг, том оврын тээврийн хэрэгслийн үнэмлэх) шаардлагатай. Аж үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд заасны дагуу дадлагажигчид сэрээт өргөгчийг тариалан газар зэрэг хувийн эдлэн газар эсвэл агуулах дотор ашиглах бол ур чадвар дээшлүүлэх сургалт болон тусгай сургалт гүйцэтгэсэн байх шаардлагатай.

Дадлагажигчид трактор болон ижил төстэй машин техникийг хувийн эзэмшилд ашиглах байлаа ч гэсэн аюулгүй байдлын лекцэд явсан байх шаардлагатай. Эдгээр лекцэд хаана сууж болох талаарх мэдээллийг хөдөө аж ахуйн их сургууль, дүүргийн зөвлөх төв, Японы хөдөө аж ахуйн хоршоо (JA), газар тариалангийн тоног төхөөрөмж борлуулах цэгээс авч болно.


Газар тариалангийн машин техник, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангах

Дадлагажигчид газар тариалангийн бүтээгдэхүүнүүд (цаашид “газар тариалангийн машин техник, тоног төхөөрөмж” гэх) бэлтгэх, ялгах, савлах, боох машин, тоног төхөөрөмж дээр ажиллах үед осолдох, бэртэж гэмтэх тохиолдлууд нэмэгдсээр байна.

Эдгээр ослоудаас урьдчилан сэргийлэх аюулгүй байдлын арга хэмжээнүүд.

- ① Тоног төхөөрөмжийн их биеийн аюулгүй байдлыг хангах

Ажил эхлэхийн өмнө гинж, араа зэрэг хөдөлгөөнт эд ангиудын хамгаалалтын таг хаалттай эсэхийг шалгах, яаралтай зогсоох товчлуур хэвийн ажиллаж буй эсэхийг шалгах.



② Үзлэг хийж, шаардлагатай бол цэвэрлэ

Газар тариалангийн машин техник, тоног төхөөрөмж хэвийн ажиллахгүй бол осол гарах аюултай байдаг. Тиймээс сэлбэг, эд ангиудыг сайтар цэвэрлэж, тослож, шаардлагатай бол соль.

Мөн машин, төхөөрөмжийн эргэн тойронд байгаа утас, кабел зэргийг хүн тээглэж унахаас сэргийлэн эмх цэгцтэй байрлуул.

③ Байнгын бус ажлын аюулгүй байдлыг хангах

Техникийн дадлагажигчдад тохиолдсон ослуудыг авч үзэхэд гацсан машины гацааг тайлах гээд дотор нь гараа хийж байхдаа эсвэл цэвэрлэх гээд гараа хийж байхдаа осолдсон тохиолдлууд байна. Эдгээр ослууд нь голдуу машин, тоног төхөөрөмжид алдаа гарсан зэрэг байнгын бус ажлын явцад тохиолдох нь бий.

Гараа хөдөлгөөнт буюу эргэдэг эд анги дотор хийхийн өмнө машины бүх эд ангиуд хөдөлгөөнгүй болтлоо бүрэн унтарсан эсэхийг шалгаад залгаастай утас кабелийг салгасан эсэхийг шалга. Хажууд байгаа хүмүүс унтраалгад санамсаргүй хүрэхээс сэргийлэхийн тулд “машин техникийн алдааг шалгаж байна” гэдгээ тэдэнд хэлээд, бас машин техник “үзлэгт орж байна” гэсэн тэмдэг тавь.



Энд Seiri Seiton (ялгаж салгах & эмхлэн цэгцлэх) чухал бөгөөд шалны аюулгүй байдлыг анхаарах хэрэгтэй.



Бусад хүмүүс унтраалга дээр санамсаргүй дарахаас сэргийлэн анхааруулгын тэмдэг тавь.

Бут сөөгийн анжистай аюулгүй харьцах

Трактороос үүдэлтэй ослууд газар тариалангийн ажил дээрх эндэгдлийн дийлэнх хувийг эзэлдэг. Ослын тоонд бэртэл гэмтлийг оруулбал бут сөөгийн анжисаас үүдэлтэй ослууд нэлээд их байна. Бут сөөгийн анжис дээр ажиллахад анхаарах аюулгүй байдлын арга хэмжээ.

① Аюулгүй байдал ба эрүүл ахуйн сургалт

Ажилчид бут сөөгийн анжис дээр ажиллахын тулд аюулгүй байдлын сургалтад явах шаардлагатай. Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр ба нийгмийн халамжийн мэдэгдэл дэх “Бут сөөгийн анжис дээр ажилладаг хүмүүст зориулсан аюулгүй байдлын сургалт” (2000 оны 2-р сарын 16-ны өдрийн 66 дугаар мэдэгдэл) (зөвхөн япон хувилбар)-д аюулгүй байдал, эрүүл мэндийн боловсролын сургалтын хөтөлбөрийг танилцуулсан байгаа.

② Бут сөөгийн анжис сонгох

Овор хэмжээ, үр бүтээмжийг нь харгалзан тухайн ажилд нийцсэн бут сөөгийн анжис сонго. Бут сөөгийн анжисын аюулгүй байдлыг тодорхойлохын тулд аюулгүй байдлын үзлэгт орсон гэрчилгээ бүхий бут сөөгийн анжис сонгож ашигла. Боломжой бол бут сөөгийн анжисын бариулаас гараа авахад мотор ньавтоматаар зогсдог бут сөөгийн анжис ашигла.

<Аюулгүй байдлын үзлэгт орсон гэрчилгээ>




(Жич) NARO нь National Agriculture and Food Research Organization буюу Үндэсний хөдөө аж ахуй, хүнс судалгааны байгууллага гэх нэршлийн товчлол юм. Газар тариалангийн ажлуудад ихээхэн тохиолдох осол эндэгдлийн улмаас өмнө хийдэг байсан үзлэгийг халж, оронд нь аюулгүй байдлын шинэ үзлэгийг (дурын үзлэг) FY2018 оноос эхлэн хийх болов. Дэлгэрэнгүй мэдээллийг NARO вэб сайтаас авна уу.
<https://www.naro.go.jp/laboratory/iam/contents/test/index.html>

③ Үзлэг, засвар үйлчилгээ, тохируулга

Хөрөөт ир нь олон зүйлд тохирдог учраас огтлох ажилд ихэвчлэн ашиглагддаг. Ирийн үзүүр тасарч агаарт шидэгдэх аюултай учраас ирэнд элдэв гэмтэл, гажилт орсон эсэхийг шалга.

Хашаа болон босоо модонд ойрхон хөрөөдөхдөө нейлон дугуй хөрөө ашигла. Учир нь ийм төрлийн хөрөө нь хашаа, мод цохиход ноцтой аюул гардаггүй.



Цахилгаан гар хөрөө

Шидэгдсэн хэлтэрхийнээс хамгаалах тагийг салгаж тавих нь өвс нөгөө тээглэх эрсдэлтэй тул бүү салгаж тавина уу. Мөрний оосортой бут сөөгийн анжис дээр ажиллах бол оосрын уртыг өөрийн биеийн өндөр намд тааруул. Хэрэглэж дууссан бол ирийг заавал шалгаж шаардлагатай бол цэвэрлэ.



Хамгаалалтын тагийг бүү салга!

④ Хамгаалалтын хувцас, хэрэгсэл

Нүдээ хамгаалахын тулд нүдний шил, нүүрний хамгаалалт зүү.

Урт ханцуй, урт өмд, дуулга, ажлын гутал, хамгаалалтын арьсан бээлий өмс.

Шаардлагатай бол шилбэний хамгаалалт зүү.

⑤ Бэлтгэл ажил

Ажил эхлэхийн өмнө яаралтай унтраах товчлуур, нээлхий зэргийг яаралтай нээх механизмтай сайтар танилц.

Бут сөөгийн анжис нь дуу чимээ ихтэй учраас ажиллуулж байгаа хүн нь бусдыг сонсохгүй байж болно. Тиймээс тэдний анхаарлыг татахын тулд дохио зангаагаар харилц (жишээлбэл хоёр гараараа даллан моторыг зогсоохыг шаардах).

Бут сөөгийн анжисыг асааж ашиглахын өмнө эргэн тойронд буй чулуу, мөчир, утас, хоосон лааз зэргийг зайлуул.



Ажил эхлэхийн өмнө чулуу, мөчир, утас, хоосон лааз зэргийг зайлуул.

⑥ Ажлын явцад

Ажлын журмыг урьдчилан шийдсэний дагуу даган мөрдөж, өөрт ногдсон ажлын талбар дотор л ажилла.

Бут сөөгийн анжисын ир ямар нэгэн зүйлд тээглэхэд анжис арагшаа хүчтэй “тийрч” болзошгүй тул анхаарал болгоомжтой бай.

Налуу газар ажиллах нь аюултай. Гишгэх тавцангууд (барилгын шатанд зориулсан банз, шатны бэхлүүр зэрэг) байрлуулж, дээш доошоо явахгүйгээр өндөрлөг газар ажиллаж байгаа хүмүүс нь дээд хэсэгтээ, нам доор ажиллаж байгаа хүмүүс нь доод хэсэгтээ ажиллавал аюулгүй. Олон ажилчид нэг дор ажиллаж байгаа бол хүн хоорондын зай хамгийн багадаа 15 метр байх ёстой.



Анжисыг аюулгүй ашиглах

① Анжис сонгох

Аюулгүй байдлын үзлэгт орсон гэрчилгээ бүхий анжис ашигла.

② Үзлэг, засвар үйлчилгээ

Моторын тосны түвшин, ремень
сул эсвэл гэмтэлтэй эсэх, савар
сул эсвэл гэмтэлтэй эсэх,
хамгаалалтын таг, коонс, тоормос
нь хэвийн ажиллаж буй эсэхийг
гарын авлагын дагуу шалга.

Үзлэгийг байнга, ажил эхлэхийн
өмнө хийдэг байх ёстой.

Хэрэв гарын авлагыг гээж алга
болгосон бол үйлдвэрлэгчийн
вэб сайтаас эсвэл фермерийн
төрөлжсөн дэлгүүрээс хуулбарыг нь олж авна уу.



Үзлэг, засвар үйлчилгээг хэрэглэгчийн гарын авлагад заасны дагуу хийнэ үү.
(Бүх загварууд)

③ Бэлтгэл ажил

Ажил эхлэхийн өмнө яаралтай зогсоох унтраалга болон аюулгүй байдлын дараах функцүүдийг
хэрхэн ашиглах талаар танилцана уу (загвараасаа шалтгаалан өөр өөр байж болно).

○Хавчигдахаас сэргийлэх төхөөрөмж (яаралтай зогсоох хөшүүрэг)

Оператор арагшаа ухрахад комбайн ба өөр ямар нэгэн объектын хооронд хавчигдах эрсдэл
үүсэхэд гол коонсыг идэвхгүйжүүлэх үүрэгтэй төхөөрөмж

○Аваарын коонс

Оператор коонсоос гараа авахад комбайны цахилгаан тэжээлийг таслах үүрэгтэй коонс (харин
жирийн коонс нь цахилгаан тэжээлийг таслахын тулд оператороос коонсыг татахыг шаарддаг)

○Зогсоолын тоормос

Анжисыг налуу, уруу газар хөдлөхөөс сэргийлэх тоормос

④ Ажлын явцад

Осолд эндэгдсэн хамгийн түгээмэл тохиолдолд оператор арагшаа ухрахдаа хана эсвэл мод ба
урдаа байгаа машины хооронд хавчигдах тохиолдлууд гарсан байдаг.

○Тиймээс оператор нь ухрахдаа хурдаа

сааруулж консоо түргэн салгахад бэлэн байх
ёстой.

○Анжисаар давчуу орон зайд арагшаа бүү ухар.



Оператор арагшаа ухрахдаа мод мөргөж осолдсон нь

Эргэлдэх эд ангиудад тээглэх тохиолдлууд нэлээд их гарсан байдаг.


- Саварт тээглэсэн шивээ, сүрэл зэргийг салгахын өмнө моторыг заавал унтраа.
- Анжисын саврыг ажиллуулахгүйгээр арагшаа ухрах, эргэх, хөдлөхдөө ротор консыг салга.
- Ременийг хамгаалалтын тагаар тагла.



Сүрэл зэргийг салгахын өмнө моторыг унтраа.

Машин хөлбөрч, хөмөрсний улмаас бэртэж гэмтэх тохиолдлууд байдаг.

- Тиймээс эргэхдээ хурдаа сааруулж чөлөөтэй эргэх боломжтой эсэхийг харгалз.
- Тариалан газар, цагаан будааны талбайн нурууг тэгш өнцөгт жолоодон орж гар. Шаардлагатай бол хөлийн тулгуур ашигла.
- Мөр давсан шарил ургамал ургасан замд ойртож үл болно.



Хөлбөрөх аюул (будааны талбайн нуруу хооронд жолоодох үед)

Газар тариалангийн машин техникийг (трактор, газар тариалангийн тээврийн хэрэгсэл) аюулгүй ашиглах

① Трактор сонгох

Япон улсад борлуулагдаж буй тракторуудын дийлэнх нь аюулгүй байдлын үзлэгт орсон гэрчилгээтэй байдаг. Гэсэн хэдий ч зарим тракторууд дээр ажиллах үед жил бүр осол гарч эндэгдсэн тохиолдлууд байна.

Тиймээс хуучин загваруудыг ашиглахгүй байхыг зөвлөж байна. Учир нь эдгээр нь хамгаалалтын кабингүй (суудал дээрх дээвэр, шилэн цонх бүхий) эсвэл хамгаалалтын араамгүй (суудлын ард байдаг ган бүтэц) байдаг.

② Үзлэг, засвар үйлчилгээ

Ажил эхлэхийн өмнө дараах эд ангиудыг гарын авлагад заасны дагуу тогтмол үзлэгт оруулж байна уу.

○Дугуйны хий, дугуйны гэмтэл, сул боолт, моторын тос, хөргөх шингэний түвшин хэвийн эсэх, сул ремень, тоормосны зүүн баруун холболт ба функц, таг болон хүчин чадлыг сонгох (PTO) босоо амны таг, хэмжигч, гэрэл, толь, хөдөлгүүрийн дуу чимээ зэргийг шалга

③ Бэлтгэл ажил

Ажил эхлэхийн өмнө дараах зүйлүүдийг шалга.

- Оператороос өөр бусад ажилчид ямар хариуцлагатай вэ? (оператороос өөр бусад ажилчид тракторын ойр хавьд бас ажиллах уу?)
- Тухайн өдөр ажиллах ажлын талбар ямар нөхцөл байдалтай байна вэ? (Харагдац багатай, налуу ташуу газартай, будааны тариалан хоорондын нуруутай, гол горхи зэрэг аюул эрсдэлтэй нөхцөл бий юу?)
- Шөнө орой ажиллах бол холын гэрэл асаа.
- Яаралтай үед бусадтай холбоо барих гар утас авч яв.
- Дуулга зүүж, хамгаалалтын бүс бүсэл.

④ Ажлын явцад

Дараах зүйлсийг анхаар.

○ Дуулга зүүж, хамгаалалтын бүс бүсэл.

○ Эргэхдээ хурдаа сааруулж чөлөөтэй эргэх боломжтой эсэхийг шалга.

○ Тариалан газар, цагаан будааны талбайн нурууг тэгш өнцөгт алгуурхан жолоодон орж гар.

Шаардлагатай бол хөлийн тулгуур ашигла.

○ Зам дээр жолоодохдоо баруун зүүн тоормосыг зэрэг ашигла.

○ Мөр давсан шарил ургамал ургасан замд ойртож үл болно.



Өндөр хурдтай огцом эргэхийг хориглоно.



Тариалан газарт тавчуу хэсгээр бүү орж гар.



Нурах эрсдэлтэй замын ирмэг дээр болгоомжтой жолоод.

○ Роторт тээглэсэн гадны биетийг салгахын өмнө моторыг заавал унтраа.

○ Трактор дээр нэмэлт суудалгүйгээр хоёр хүн зэрэг зорчихыг хориглоно. Машины ард давхарлан суухыг хориглоно.



Жолоочын арын суудал дээр суун зорчиж үл болно.

◆ нийтийн зам тээвэрт осол цөөнгүй гардаг учраас дараах нөхцөл байдалд онцгой анхааралтай жолоодоно уу.

○ Нийтийн зам тээвэрт зорчиход жолооны үнэмлэх шаардлагатай.

○ Автомашин зэрэг бусад тээврийн хэрэгсэл өөр өөр хурдтай зорчдог тул анхаарал болгоомжтой байна уу.

○ Трафик ихтэй зам дээр зорчихоос зайлсхий.

Шат, эвхдэг шат зэрэг хэрэгслийг аюулгүй ашиглах

① Газар тариалангийн багаж хэрэгсэл (зээтүү, хүрз, сэрээ, хутга, хадуур, хайч гэх мэт)

- Төхөөрөмжийг ашиглаагүй бол дугуй хөрөөг бүтээж тавь.
- Багаж хэрэгслийг олоход амархан газар байршуул.
- Ир нь суларч бариулаасаа салахаас сэргийлэн шалгаж шаардлагатай бол чангал.
- Хэрэглэж дууссан бол шороо тоос, элдэв наалдаж тээглэсэн зүйлийг цэвэрлэж дараа ашиглахад бэлэн байлга.
- Газар тариалангийн багаж хэрэгсэл ашиглахдаа эргэн тойронд буй хүмүүсээс аюулгүй зай барь.



Хөлийнхөө ойр зээтүү бүү хэрэглэ.

② Эвхдэг шат, шат

- Тогтвортой нөхцөлд ашигла.

* Эвхдэг шат, шатыг ашиглахдаа чөлөөтэй орон зай байгаа эсэх, гадаргууны хатуу, тогтвортой болон тэгш эсэхийг харгалз.

Жимсний талбайн гадаргуу зөөлөн, тэгш бус байдаг учраас эвхдэг шатыг найдвартай байрлуулах боломжгүй бол доор нь банз зэрэг хатуу материал тавь.

Эвхдэг шатыг тогтвортой байрлуулах боломжгүй бол өөр хүнээр хөдөлгөөнгүй бариулж бай.



③ Бордоо


- Бордоог доорх гүний усыг бохирдуулахгүйгээр хадгал.
- Түүхий шохойд ус нэмэхэд үүсэх дулаанаас болгоомжил.
- * Түүхий шохойг (CaO буюу кальцийн исэл) устай холиход болсон шохой үүсдэг (Ca(OH)_2 буюу кальцийн гидроксид) бөгөөд энэ нь хэт дулаан үүсгэж орчны температурыг өсгөдөг.



④ Эвхдэг шат хэт алцайхаас сэргийлэн гинжээр бэхлэл.

* Ажил эхлэхийн өмнө эвхдэг шат хэт алцайхаас сэргийлэн гинжээр бэхэлсэн эсэхийг шалга.

Шат ашиглахдаа дээд доод ирмэг нь тогтвортой байрласан эсэхийг шалга.



⑤ Эвхдэг шатан дээр авирахын өмнө эхлээд эхний гишгүүр дээр гишгэж тогтвортой эсэхийг нь шалга.

* Эхлээд эхний гишгүүр дээр гишгэж дайвалзаж буй эсэхийг нь шалга.

Шалгахдаа эхний гишгүүрээс бүү хэтэр.

Эвхдэг шатан дээр авирахдаа шатны эргэн тойронд аюултай зүйлс байхгүй эсэхийг шалга.



⑥ Эвхдэг шатны оргил тавцан дээр бүү зогс.

* Эвхдэг шатны оргил тавцан дээр зогсон ажиллаж үл болно. Тавцан дээрээс хол байгаа зүйл рүү гараа сунгаж үл болно. Ингэснээр эвхдэг шатны тэнцвэрийг алдагдуулж улмаар унаж бэртэх эрсдэлтэй юм.

⑦ Шат руу авирах, шатнаас буухдаа хүнд зүйлс бүү өргө.

* Шатан дээр ажиллахдаа хамгийн дээд даацыг бүү хэтрүүл.

Шат руу авирах, шатнаас буухдаа жимстэй хайрцаг зэрэг хүнд зүйлс бүү өргө.



Малын саравч доторх аюулгүй байдал, эрүүл ахуй

① Цэвэрлэгээ

- Малын саравч доторх коридор, тэжээлийн агуулах, тэжээлийн тэвш, усны тэвш зэргийг тогтмол цэвэрлэ.
- Ажлын гутал хувцсаа цэвэрлэ.



② Ариутгал


- Малын саравчинд орохдоо гутлаа тусгай дүрлэгт дүрж ариутга.
- Саравчинд орж гарах тээврийн хэрэгслийн дугуйг шүршигчээр шүршиж, тусгай дэвсгэр дээр гүйлгэж ариутга.
- Малын саравчинд өвчин үүсгэгч бодис орохоос сэргийлэн болсон шохой цац.

③ Үүлдэрийн малын хэвтрийг цэвэр, тухтай байлга.

- Өвлийн улиралд салхи нэвтрэх ан цавийг бөглөж малын саравчийг дулаан байлга. Зуны улиралд агааржуулагч, сэнс зэргийг ажиллуулан сэрүүн байлга.
- Малын хэвтэрийг цэвэр хуурай байлга.
- Тэжээлийн тэвш зэргийг үргэлж цэвэр байлга. Малыг уух усаар тогтмол ханга.

④ Үүлдэрийн малыг сайн арчил.

- Үүлдэрийн малын тав тухыг хангаж, тайван тогтуун байлга.
- Үүлдэрийн мал гэнэт огцом хөдөлж болзошгүй учраас ойр хавьд нь ажиллахдаа анхаарал болгоомжтой бай.



Пестицидийг аюулгүй ашиглах

① Пестицид хадгалах, тээвэрлэх

- Пестицидийг холих, шүршихээс гадна хадгалах, тээвэрлэхдээ маш болгоомжтой бай.
- * Мал аж ахуйн салбарт ариутгагч бодистой харьцахдаа газар тариалангийн салбарт пестицидтэй харьцдаг шигээ харьцах хэрэгтэй.

② Зориулалтын хамгаалалтын хэрэгсэл, хувцас өмс.


- Пестицид арьсанд хүрэхээс сэргийлэн зориулалтын хамгаалалтын хувцас, маск, бээлий, нүдний шил ашигла.
- * Зориулалтын маскын оронд алчуур зэргийг бүү ашигла.



- ① Бээлий ✓ Бээлий өмсөхдөө ханцуй дотроо углаж оруулах ✗ Ханцуйгаа давуулан бээлий өмсөх



- ② Гутал ✓ Гутлаа өмдний дотуур хийж өмсөх ✗ Гутлаа өмдний гадуур тавьж өмсөх



③ Пестицидийн савлагаан дээрх шошгыг шалга.

- Пестицидийг ашиглах зааварчилгаа дээр заасан стандартуудыг даган мөрд (ашиглах заавар, анхаарах зүйлс гэх мэт).

Жишээлбэл, ажлын байран дахь сургалтын (OJT, on the job training) үеэр дадлагажигчдад пестицидийг хэрэглэхдээ хэрхэн холих буюу шингэлэхийг үзүүлж ойлгосон эсэхийг нь шалга.



Пестицид ашиглах заавар

Пиктограммын төрөл	Анхаарал болгоомж (жишээ)	
Эмзэг арьстай хүн хэрэглэхийг хориглоно (Арьсны тууралтаас болгоомжил)		Тус ажлыг эмзэг арьстай хүн хийж үл болно. Тус химийн бодисыг шүршсэн ургамалд бүү хүр.
Зөгийн үүрэнд шүршиж үл болно (Анхаар, балт зөгий)		Тус химийн бодисыг зөгийн үүрэнд буюу үүрний ойр хавьд шүрших эрсдэлтэй бол бүү ашигла.
Байгууламж дотор ашиглахыг хориглоно		Ногоон хүлэмж зэрэг шүршсэн зүйл дотор нь хуримтлаж болзошгүй битүү орчинд ашиглаж үл болно.

Эх сурвалж: Crop Life Japan (Японы ургац хамгаалах нийгэмлэг) вэб сайт "Пестицидтэй холбоотой асуулт хариултууд- Пестицид аюулгүй юу?- (Тариаланчдад зориулсан пестицид хэрэглэх талаарх аюулгүй байдлын арга хэмжээ)" (Зөвхөн япон хувилбар) https://www.jcpa.or.jp/qa/a_5_18.html

Наршилт гэдэг нь өндөр температур, чийгшилтэй орчинд хүний биед ус, давсны (натрийн) тэнцвэр алдагдаж, дулааныг зохицуулах чадваргүй болох үед үүсдэг эмгэгийг хэлнэ. Японы анагаах ухааны нийгэмлэгээс гаргасан 2024 оны Наршилтыг оношлох удирдамжид наршилтыг ноцтой байдлаар нь 1 - 4 түвшинд ангилдаг.

Ангилал	Шинж тэмдэг	Эмчилгээ	Ноцтой байдал
1 -р түвшин	Толгой эргэх, ухаан алдах (хэвтээ, суунга байршлаас гэнэт босоход толгой эргэх), зүүрмэглэхгүйгээр эвшээх, их хөлрөх, булчин өвдөх, булчин хөших (хөлний шөрмөс татах)	Ажлын байранд эмчилж болно. Нарнаас хол, сэрүүн өрөөнд сэрүүцүүлнэ. Сэрүүцэх боломгүй бол эйр кондишнтэй (идэвхгүй сэрүүцүүлэлт гэнэ) өрөөнд амарч, ус ууж биеийн шингэн болон электролитийг нөх. Хэрэв энэ хангалтгүй бол идэвхтэй сэрүүцүүлэх арга хэмжээ ав (наршсан хүнийг өөр ямар нэгэн аргаар сэрүүцүүлэх).	Бага ↓ Өндөр
2 -р түвшин	Толгой өвдөх, бөөлжих, ядрах, нозоорох, анхаарал төвлөрөл болон шийдвэр гаргах чавар буурах	Эмнэлэгт хүргэж эрүүл мэндийн үзлэгт оруулах шаардлагатай. Судсаар дусал хийх хэрэгслийг ашиглахын өмнө хөргөгчинд эсвэл нарнаас хол сэрүүн өрөөнд, болохгүй бол эйр кондишнтэй өрөөнд хадгалсан байх шаардлагатай. Хэрэв эдгээр арга хэмжээний аль нэг нь эсвэл аль аль нь үр дүнгүй бол ус ууж биеийн шингэн болон электролитийг нөхөж, идэвхтэй сэрүүцүүлэх арга хэмжээ ав.	
3 -р түвшин	Дараах 3 шинж тэмдгүүдийн аль нэг нь илэрвэл - Төв мэдрэлийн системийн шинж тэмдэг (ухаан балартах, таталт үүсэх) - Элэг, бөөрний үйл ажиллагааны саатал - Цус өтгөрөлт	Түргэн тусламж яаралтай дуудах шаардлагатай. Эмнэлэгт эмчилгээ хийлгэсний дараа, идэвхтэй сэрүүцүүлэлт багтаасан олон талт эмчилгээ шаардлагатай байж болно.	
4 -р түвшин	Биеийн температур 40 хэм буюу үүнээс илүү, наршсан хүн ярих чадалгүй болсон	Түргэн тусламж яаралтай дуудах шаардлагатай. Идэвхтэй сэрүүцүүлэлт багтаасан олон талт эмчилгээг нэн даруй үзүүл.	

2023 онд бүх салбаруудад наршилтын улмаас ажлаасаа 4 буюу үүнээс илүү хоногоор чөлөө авсан ажилчдын нас барсан, гэмтсэн тоо нийт 1106 байснаас 31 нь нас барсан тоо баримт байна. Эдгээрээс хөдөө аж ахуйн салбарт эндсэн, бэртсэн хүмүүсийн тоо 27 байсан (нийт хэмжээний 2.4%) бөгөөд эдгээрийн 4 нь нас барсан (нийт хэмжээний 12.9%).

Газар тариалангийн ажлыг ихэвчлэн гадаа, заримдаа ногоон хүлэмж зэрэг битүү орчинд хийдэг. Ийм орчинд их чийгтэй, халуун бөгөөд ялангуяа зуны саруудад нарших эрсдэл өндөр байдаг.

WBGT утга (наршилтын индекс)

WBGT утгыг наршилтыг үнэлэхэд наршилтын индекс болгон ашигладаг.

WBGT утга нь хүний бие ба гаднах агаарын (дулааны тэнцвэр) хоорондын дулааны солилцоонд төвлөрдөг үзүүлэлт бөгөөд биеийн дулааны тэнцвэрт байдалд чухал нөлөө үзүүлэх гурван хүчин зүйл болох (1) чийгшил, (2) нарны илч, цацрагийн дулаан зэрэг гадны илч, (3) температурыг авч үздэг.

WBGT утга хэдий чинээ өндөр байна нарших эрсдэл төдий чинээ өндөр байна.

WBGT утгыг хар баллонтой мэдрэгч бүхий WBGT хэмжих төхөөрөмж ашиглан хэмждэг (Японы аж үйлдвэрийн стандарт JIS Z8504 буюу JIS B 7922-д нийцэх).

Хэрэв ийм төхөөрөмж ашиглах боломжгүй бол урьдчилан таамагласан болон бодит WBGT утгуудыг Байгаль орчны яамны Наршилтаас урьдчилан сэргийлэх тухай мэдээллийн вэб сайт руу орж шалгах боломжтой. (https://www.wbgt.env.go.jp/wbgt_data.php).

Газар тариалангийн ажил ба дулааны индекс

WBGT утга нь стандарт утгыг давах (эсвэл давах эрсдэлтэй) үед (халуун, чийгтэй) ажилчид нарших эрсдэл маш өндөр байдаг. Тиймээс ажилчдыг ажиллаж байх үед нь WBGT утгыг хэмжихийг аль болох хичээх нь чухал юм.

Хэмжигдсэн WBGT утгыг доорх хүснэгт дэх стандарт утгуудтай харьцуулан, шаардлагатай гэж үзвэл халуун чийгтэй орчинд дараах арга хэмжээг авбал зохино.


- ① WBGT утгыг багасгахын тулд “нарны гэрлийг халхлах саравч” болон “агааржуулалт, эйр кондишн” ашиглах.
- ② Халуун, чийгтэй орчинд ажиллахдаа эйр кондишнтай сэрүүцүүлэх бүс, сүүдэртэй сэрүүн газрыг тусгайлан бэлдэх.
- ③ Халуун, чийгтэй орчинд ажиллах бол мөс ашиглах, хүйтэн жин тавих, хүйтэн шүршүүрт орж сэрүүцэхийг аль болох хичээх хэрэгтэй.
- ④ Ажилчидыг алдсан шингэн, давсаа тогтмол нөхөж байхын үүднээс уух ус бэлэн байлгавал зохино.

Хөдөлмөрийн эрчим	Жишээ	Наршилтын индекс (WBGT) Лавлах утга
Амрах	Амрах	33 (халуун орчинд ажиллаж дасаагүй хүмүүст 32)
Хөнгөн ажил	- Босоогоор, суунгаа хийх хөнгөн ажил (бичих, данс хөтлөх) - Гар ажил (үзлэг хийх, угсрах, түүхий эд ангилах) - Гар хөлөө оролцуулан ажиллах (тээврийн хэрэгслийг хэвийн нөхцөлд жолоодох, тоормос, хааз зэрэг гишгүүр ашиглах)	30 (халуун орчинд ажиллаж дасаагүй хүмүүст 29)
Дунд зэргийн ажил	- Трактор зэрэг хүнд оворын машин жолоодох, жимс ногоо хураах - Хөнгөн оворын түрдэг тэрэг түрэх, татах	28 (халуун орчинд ажиллаж дасаагүй хүмүүст 26)
Хүнд ажил	- Гар ашиглан хүрдэх, хяргах, ухах, хөрөөдөх - Хүнд оворын түрдэг тэрэг түрэх, татах	25 (халуун орчинд ажиллаж дасаагүй хүмүүст 22)
Маш хүнд ажил	Хүрзээр шороо малтах, сүхээр чавчих, шатаар авирах, гүйх	23 (халуун орчинд ажиллаж дасаагүй хүмүүст 18)



Энэхүү мэдээллийг Японы аж үйлдвэрийн Z8504 стандарт дахь Хавсралт А (Дулааны орчны эргономик – WBGT (баллон бөмбөрцгийн температур) индексийг ашиглан наршилтын үнэлгээ) (зөвхөн япон хувилбар) -ын "WBGT наршилтын индексийн жишиг утга" хавсралт болон "Хөдөө аж ахуйн ажилд наршилтаас сэргийлэх арга хэмжээг цаашид сайтар хэрэгжүүлэх" (зөвхөн япон хувилбар) нийтлэл дээр үндэслэн гаргасан болно. Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуурын яамны Газар тариалангийн товчооны Газар тариалангийн үйлдвэрлэлийн материалын албаны Технологи, өргөтгөлийн хэлтсийн даргын Тамгын газрын 2024 оны 7 дугаар сарын 10.

Хэрэв наршсан хүний ухаан нь балартсан, ус уух чадалгүй, анхны тусламж өгсний дараа ч нөхцөл байдал нь сайжрахгүй бол эмнэлэгт нэн даруй хүргэж үзлэгт оруулах шаардлагатай.



Доод нуруу өвдөхөөс сэргийлэх арга хэмжээ

Газар тариалангийн ажилд доод нуруу өвдөхөөс урьдчилан сэргийлэхийн тулд хөдөлмөрийн эрүүл мэндийн цогц, тасралтгүй сургалтыг хэрэгжүүлж, ажил, ажлын орчин ба эрүүл мэнд гэсэн 3 хүчин зүйлийг зохицуулах нь чухал юм.

Энэ хүрээнд дараах арга хэмжээнүүд үр дүнтэй.

① Автоматжуулалт

Хэрэв тухайн ажил нуруунд ачаалал өгөх хүнд оворын зүйлстэй харьцах, эсвэл тухгүй байрлалд ажиллахыг шаардах бол машин ашиглаж ажлын процесийг автоматжуулбал зохино. Хэрэв ингэх боломжгүй бол түрдэг тавцан зэрэг бие махбодод үзүүлэх ачааллыг багасгаж ажлыг хөнгөвчлөх арга замыг сүвэгчилнэ үү.

② Биеийн байрлал, хөдөлгөөн

Ажилчид тухайн объектод биеэрээ аль болох ойртож ажиллах ёстой. Хэрэв тухайн ажил тухгүй байрлалд ажиллахыг шаардах бол тонгойх, эргэх зэргээр тухгүй байрлалыг аль болох багасгах нь чухал.

Ажлын ширээ, сандлыг зохих өндөрт тохируул.

Ажлын ширээг ажилчны тохионы өнцгийг 90 градус тавиулахаар тохируул.



Түрдэг тавцан ашигла.

③ Ажлын арга барилыг тогтоох

Ажлын цаг, ажлын ачааллыг гаргахдаа ажилчдын тоо, ажлын төрөл, хугацаа, хүнд жин, автоматжуулалт, ажил хөнгөвчлөх боломж зэргийг харгалзан үзэж нэг ажилчныг доод нуруунд нь хүнд ачаалал өгөхгүйгээр ганцаар нь ажиллуулахгүй байх нь чухал.

④ Ажлын стандарт тавих

Ажлын байрлал, хөдөлгөөн, ажлын журам, үргэлжлэх хугацааны талаар ажлын стандарт гарга. Ажлын стандартыг ажилчдын шинж чанар, ур чадварын түвшинг харгалзан байнга шалгаж байх шаардлагатай. Шинэ машин техник, тоног төхөөрөмжийг ажлын байранд оруулж ирэх тоолонд ажлын стандартыг дахин шалгах шаардлагатай.



Ачаа өргөхдөө явган сууж хөлөөрөө өргө.




Өргөсөн ачааг биедээ ойрхон авч яв.

⑤ Завсарлага, ажлын ачаалал, ажил сэлгэлт

Ажилчид завсарлага авч, биеийн чилээгээ гаргах боломжийг өг.

Тухгүй байрлалд нэг хэвийн үйлдэл хийхийг шаарддаг ажил хийх бол өөр үйлдэл хийдэг ажилтай хослуулан нэг байрлалд аль болох удаан ажиллахгүйг хичээ.



Хүнд оворын зүйлс өргөх арга замыг сүвэгчил.



Өргөх ачааг жижиг хэсгүүдэд хуваа.

Зөгийд хатгуулах

Газар тариалангийн ажилчид зуны улиралд зөгийд хатгуулахаас болгоомжлох хэрэгтэй. Ажилчид өндөр өвс, зүлэгтэй газар орохдоо зөгийн үүрийг анзаарахгүй зөгийд хатгуулах нь бий.

Бөхгөнө, хэдгэнэ хамгийн хортойд тооцогддог. Эдгээрээс бөхгөнө нь нэлээн догшин зан авиртай. Үүрэнд нь хэн нэгэн, ямар нэгэн зүйл ойртоход зөгийнүүд түгшүүрийн байдалд орж довтлоход бэлэн болдог.

Японд 2023 онд зөгийд хатгуулж нас барагсдын тоо 21 байсан.

Японд зөгийд хатгуулж нас барагсдын тоо

(Нэгж: хүн)

Ангилал	2019	2020	2021	2022	2023
Зөгийд хатгуулж нас барагсдын тоо	11	13	15	20	21

Эх сурвалж: Эрүүл мэнд, хөдөлмөр яам, нийгмийн халамжаас нийтэлсэн на
Зөгийд хатгуулсны дараа анафилаксийн шок үүсч аюултай нөхцөл байдал бий болдог*.

* Химийн хорт бодисоос харшил авсны улмаас маш богино хугацаанд (хэдхэн минутаас 30 минут хүртэл) амьсгал бачуурч, цусны даралт буурах амь насанд халтай ноцтой нөхцөл байдал.



Анафилаксийн шокын шинж тэмдэг

	Бүх биеийг хамарсан	Амьсгалын систем	Цусны эргэлт	Хоол боловсруулах систем	Мэдрэлийн систем	Арьс
Субъектив Шинж тэмдэг	- Айдас түгшүүр - Найдваргүй мэдрэмж	- Амьсгал давчдах - Хоолойд юм тээглэж буй мэт мэдрэмж	Зүрх дэлсэх	- Дотор муухай оргих - Хэвлийгээр өвдөх - Ялгадас хүрэх - Шээс хүрэх	- Толгой эргэх - Мэдээ алдах - Чих дүнгэнэх	- Бүх биеэр хавганах - Загатнах
Объектив Шинж тэмдэг	Хүйтэн хөлс гарах	- Найтаалгах - Хүчтэй амьсгаадах - Амьсгал давчдах	- Цусны даралт багасах - Судасны цохилт доройтох - Судасны цохилт түргэсэх	- Бөөлжих - Суулгах - Давсаг өвдөх, ойр ойрхон шээх	- Татганах - Ухаан балартах	- Бүх биеийг хамарсан гүвдрүү - Зэвхий, цонхигор болох

Зүгийд хатгуулсан бол дараах арга хэмжээг авах хэрэгтэй.

- 1 Ажилчныг хатгуулсан газраас нь нэн даруй холдуулж хорыг зориулалтын зөгийн хор гадагшлуулах багажаар гадагшлуул.
- 2 Хатгуулсан газар хүйтэн жин тавьж биен дэх хорын тархалтыг удаашруул.
- 3 Хатгуулсан хэсэгт гистамины эсрэг тос түрх.
Гистамины эсрэг шахмал эмийг шаардлагатай бол амаар уух хэрэгтэй.
- 4 Хатгуулсан хүнд арьсаар юм туурах, ханайлгах, толгой эргэх зэрэг шинж тэмдгүүд илэрвэл нэн даруй эмнэлэгт хүргэ.
- 5 Өвчтөнийг түргэн тусламжийн машин руу хүргэхдээ дамнуурга дээр тавьж зөө. Өөрөөр нь алхуулах буюу нуруун дээрээ үүрч үл болно.

Хачигаар дамжсан халдвар

Хачигт хазуулсан хүн өндөр халуурч тромбоцитопенийн хам шинж (SFTS), энцефалит, бутны хижиг, лаймын өвчний шинж тэмдгүүд илэрдэг.

Хачигийн шинж чанар болон хачигийн тухай бусад мэдээлэл.

① Хачигийн тархалт

Хачиг нь гэрийн хувалзтай (хөгцний хувалз, тоосны хувалз) адилгүй юм. Хачиг нь голдуу ой мод, өвс ногоо бараадан амьдардаг. Заримдаа хот суурин газар тохиолдох нь бий. Газар тариаланд, бут сөөг хяргах ажил хийх үед хачигт хазуулах эрсдэл байдаг.

② Хачигийн идэвхтэй цаг үе

Хачиг нь хавар намарын улирдалд илүү идэвхтэй байдаг. Гэсэн хэдий ч дулаан бүс нутагт хачиг нь өвөл ч бас идэвхтэй байдаг тул ажилчид анхаарал болгоомжтой байх нь чухал юм.

③ Урьдчилан сэргийлэлт

Хачигийн халдвараас урьдчилан сэргийлэхийн тулд хазуулахгүй байх хэрэгтэй.

Өвс ургамал, уул хадаар зорчихдоо гар хөл, хүзүүгээ ил гаргахгүй хучиж, зай завсаргүй битүү хувцас өмсөхийг зөвлөж байна.

Хэрэв хачигт хазуулсан бол

Хачиг нь арьсыг цоолж удаан хугацааны турш цус сорох нь бий (хэд хэдэн хоног заримдаа бүр 10 хүртэл хоног). Хачигт хазуулсан хүмүүс эхэндээ өвдөлт мэдрэгддэггүй учраас хэсэг хугацаанд анзаарахгүй явдаг.

Гэхдээ 2, 3 хоногийн дараа цус сорсоор байсан хачигийн бие томорч, хазуулсан газар загатнаж хорсож эхэлдэг.

Биедээ хачиг байхыг олж мэдсэн бол

Биед наалдсан хачигийг хүчээр салгах гэж оролдох нь хачигийн зарим хэсгийг арьсанд үлдээх эрсдэлтэй байдаг. Эсвэл хачигийг няцлах нь биед вирус, бактери оруулж болзошгүй юм. Тиймээс тусгай эмнэлэгт хандах хэрэгтэй (арьсны эмч зэрэг).

Хачигт хазуулсан бол

Хэрэв хачигт хазуулсан бол биеийн байдлаа 3 долоо хоногийн турш хянаж, халуурах, ядрах, арьсаар юм туурах, үе мөч өвдөх, хэвлийгээр өвдөх, суулгах зэрэг шинж тэмдгүүд илэрч буй эсэхийг анзаарна уу. Хэрэв эдгээр шинж тэмдгүүдийн аль нэг нь илэрвэл эмчид яаралтай хандаж хачигт хазуулсан (хэзээ, хаана, биеийн аль хэсэгт) гэдгээ мэдэгдэнэ үү.

Лавлагаа: Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуурын яамны Газар тариалангийн товчоо, Технологи, өргөтгөлийн хэлтсийн дарга “Хөдөө аж ахуйн ажилд хачигт хазуулахтай холбоотой чухал мэдээллүүд” (зөвхөн япон хувилбар) 2013 оны 2-р сарын 25 - 24 2933 дугаар нийтлэл

Хүчил төрөгчийн дутагдал болон бусад ослууд

Жил бүр хүчил төрөгчийн дутагдал, устөрөгчийн сульфидын хордлого (хүчил төрөгчийн дутагдал болон бусад ослууд) үүсдэг. Эдгээр ослуудын зарим нь амь насанд халтай байдаг.

Хүчил төрөгчийн дутагдлаас үүдэлтэй нас баралтын хэмжээ өндөр хувийг эзэлдэг. Нас баралтын шалтгаануудын нэг нь гэвэл ажилчид хүчил төрөгч дутагдаж байгааг анзаарахгүй явснаас болсон байдаг. Үүнээс урьдчилан сэргийлэхийн тулд ажлын байранд хяналт хийх, агааржуулалт суулгах, амьсгалын аппарат, маск зэрэг хэрэгслийг ашиглах шаардлагатай.

Хүчилтөрөгч дутагдах, устөрөгчийн сульфидийн хордлого зэрэгтэй холбоотой ослын тохиолдол




Эх сурвалж: “Хүчил төрөгчийн дутагдал болон устөрөгчийн сульфидын хордлогын улмаас ажил дээр осол гэмтэл гарсан тохиолдлууд”
(Зөвхөн япон хувилбар) Эрүүл мэнд, хөдөлмөр яам, нийгмийн халамжийн вэбсайтаас
(https://www.mhlw.go.jp/stf/newpage_05929.html)

Хүчил төрөгч багатай зэрэг аюултай орчин

Агаар дахь хүчил төрөгчийн концентрац 18%-аас бага, эсвэл агаар дахь устөрөгчийн сульфидын концентрац нэг саяд 10 нэгжээс хэтэрвэл хүчил төрөгчийн дутагдал үүсдэг. Газар тариалангийн салбарт дараах нөхцөл байдалд хүчил төрөгчийн дутагдал үүсдэг тул ажиллахад аюултай болдог.


① Борооны ус хуримтлагдсан хоолой, цистерн дотор

(Газар доорх төмөр исэлдсэнээс, бичил биетүүд хүчил төрөгч идсэний улмаас хүчил төрөгчийн дутагдал үүсдэг)



Үржих бичил биетүүд хүчил төрөгчөөр амьсгалсаны улмаас хүчил төрөгч багасдаг.

- ② Үр тариа, тэжээлийн агуулах, жимс ногоо боловсруулах тасалгаа, үр соёололт, мөөг тариалахад ашигладаг силос, зоорь, агуулах, хонхор, цооног (үр тариа хүчилтөрөгчөөр амьсгалдаг учраас)



Өвс, үр тарианы амьсгалалт

Мөн газар тариалангийн салбарт бохир ус, хөрсний өмхрөл, хаягдал ус, ялзмаг болон бусад амархан ялзардаг бодис агуулсан сав, цистерн, хоолой, дамжуулах хоолой, нүх, суваг шуудуу дотор сульфат бууруулах бактерийн улмаас устөрөгчийн сульфидын хордлого үүсч болзошгүй юм.



Устөрөгчийн сульфид үүссэн нь

Хүчил төрөгчийн дутагдал болон бусад ослоудаас урьдчилан сэргийлэх

- ① Хүчил төрөгч багатай орчинд ажиллахын өмнө шалгах.
- ② Хүчил төрөгч багатай орчны мэргэжилтэнг томилох.
- ③ Хүчил төрөгч, устөрөгчийн сульфидын концентрацийг хэмжих.
- ④ Ажилчдад хүчилтөрөгч багатай орчинд ажиллах тухайд тусгай сургалт явуулах.

* Ажилчдыг хүчил төрөгч багатай орчинд ажиллуулахдаа урьдаар хүчил төрөгчийн дутагдах шалтгаан, шинж тэмдэг, амьсгалын аппарат ашиглах, ухаан балартсан хүнийг нүүлгэн шилжүүлэх, сэхээх, түргэн тусламж үзүүлэх тухайд тусгай сургалт явуулах шаардлагатай.

- ⑤ Агааржуулалт
- ⑥ Хамгаалалтын хэрэгсэл ашиглах.
- ⑦ Түргэн тусламж
- ⑧ Дам ослоос урьдчилан сэргийлэх (осолдсон хүнийг аврахдаа амьсгалын аппарат зүүх).
- ⑨ Бусад арга хэмжээнүүд

① Харилцаа холбоо

- Техникийн дадлагажигчтай харьцах нь тэдний япон хэлний түвшинг ойлгож, амьдралын хэв маягийн ялгааг олж харахад тусална. Ингэснээр аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээг ажлын төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх боломжтой юм.

② Дадлагажигчдад аюулгүй байдал, эрүүл ахуйн нэр томъёоны, пайз тэмдгийн тухай ойлголтыг нэмэгдүүлэх.

- Аюулгүй байдал, эрүүл ахуйн нэр томъёоны, пайз тэмдгийг тэдэнд ойлгомжтой болгохын үүднээс эх хэл дээр нь тайлбарлаж өгөх.

③ Япон улсад ирсний дараа аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад цаг алдалгүй хамрагдахын ач холбогдол

- Дадлагажигчид аж үйлдвэрийн осолд илүү өртөмтгий байдаг учраас тэднийг осол бэртлээс урьдчилан сэргийлэхийн тулд дадлагад элсүүлэхдээ аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад оруулах нь чухал юм.
- Япон улсад анх удаа ажиллаж байгаа дадлагажигчдад ажлын арга барилыг аль болох ойлгомжтой байлгахын тулд жишээ, практик хэлбэрээр тэдэнд үлгэрлэн үзүүлэх нь зүйтэй.

④ Өдөр тутмын аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагаа явуулах.

- Дадлагажигчид Япон улсад ажиллаж эхлээд ажлын дадал, туршлагатай болсон ч гэсэн өдөр тутмын аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагаа явуулах. (5 S , TBM болон KYK) .

⑤ Шуурхай арга хэмжээ авах шаардлагатай үед

- Дадлагажигчдыг аюултай, хориотой зүйлсийн талаар ойлгох хэмжээнд япон хэлийг нь сайжруулж өгөх байнгын сургалт явуулах. Онцгой нөхцөл байдал гарахад шуурхай арга хэмжээ авах тухайд хэнтэй холбоо барих тухайд мэдээллийн самбар дээр тайлбарлан бичиж үлдээх.
- Дадлагажигчдад осол гарсан үед эргэн тойронд байгаа хүмүүстээ чанг дуугаар мэдэгдэж, аль болох тайван байх талаар зааж өгөх.

⑥ GAP гэрчилгээ

- Хүнсний аюулгүй байдал, байгаль орчны хамгаалалт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангахын үүднээс Японы хөдөө аж ахуйн салбарт GAP (Good Agricultural Practice буюу Газар тариалангийн сайн дадал) гэрчилгээг авах тал дээр ихээхэн ач холбогдол өгдөг гэдгийг дадлагажигчдад тайлбарлаж өгөх.


Аж үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд заасны дагуу хэрэгжүүлэгч байгууллагууд техникийн дадлагажигчдыг эрүүл мэндийн үзлэгт оруулах шаардлагатай байдаг.

Эрүүл ахуйн ерөнхий үзлэг

Шинэ техникийн дадлагажигчдыг элсүүлэхдээ хуульд заасны дагуу дараах үзлэгт оруулах шаардлагатай. (Аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 43 дүгээр зүйл)

Техникийн дадлагажигчдыг элсүүлэхэд хийх үзлэгүүд ① -ээс ⑪.

- ① Эрүүл мэнд, хөдөлмөрийн түүх
- ② Субъектив, объектив шинж тэмдгүүд
- ③ Биеийн өндөр, биеийн жин, бүсэлхийн тойрог, хараа, сонсгол
- ④ Цээжний рентген шинжилгээ
- ⑤ Цусны даралт
- ⑥ Цус багадалтын шинжилгээ (гемоглобины агууламж ба эритроцитын шинжилгээ)
- ⑦ Элэгний үйл ажиллагаа (GOT, GPT, γ -GTP-ийн шинжилгээ)
- ⑧ Цусан дахь липидийн түвшин
- ⑨ Цусан дахь сахарын түвшин
- ⑩ Шээсний шинжилгээ (шээсэн дэх сахар, уургийн агууламж)
- ⑪ Электрокардиограммын шинжилгээ



Ажилд элсүүлэх үед эрүүл мэндийн үзлэгт оруулах нь ажилчдыг зөв ажил даалгаварт хуваарилах, мөн тэдний эрүүл мэндийн байдлыг зөв зохицуулахад тус дэмтэй юм. Сүүлийн хэдэн жилүүдэд гадаадаас ирсэн ажилчдад сүрьеэ өвчин илэрсэн тохиолдлууд нэмэгдсэн учраас цээжний рентген шинжилгээ хийж сүрьеэ өвчинтэй эсэхийг магадлах шаардлагатай.

<Ажил дээр халдвар гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ (сүрьеэ) - Сүрьеэ өвчин илрэхэд авах хариу арга хэмжээ ->

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тухай, өвчтөнд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд заасны дагуу сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээг хэрэгжүүлнэ. Сүрьеэ өвчин илэрсэн эмнэлгийн байгууллагуудаас бусад ажлын байранд гарсан тохиолдолд сүрьеэгийн халдвар авсан эсвэл авсан байж болзошгүй хүмүүсийг түргэн шуурхай илрүүлж, хариу арга хэмжээ авахын тулд өртсөн хүнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах нь чухал юм.

Нийгмийн эрүүл мэндийн төвөөс ирсэн зааврын дагуу ажиллана. Байгууллагууд нь өртсөн ажилчдыг илрүүлж, байнгын үзлэгт ороогүй ажилчдыг үзлэгт оруулахыг шаардаж, өртсөн хүмүүсийг шуурхай үзлэгт оруулах үүрэгтэй юм.

Эрүүл ахуйн байнгын үзлэг

Бүтэн цагаар ажилладаг ажилчдыг (техникийн дадлагажигчид) хуульд заасны дагуу жилд нэг удаа үзлэгт оруулах шаардлагатай. (Аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 44 дүгээр зүйл)

Жилд нэг удаа хийх үзлэгүүд ① -ээс ⑪.

- ① Эрүүл мэнд, хөдөлмөрийн түүх
- ② Субъектив, объектив шинж тэмдгүүд
- ③ Биеийн өндөр, биеийн жин, бүсэлхийн тойрог, хараа, сонсгол
- ④ Цээжний рентген шинжилгээ, цэрний шинжилгээ
- ⑤ Цусны даралт
- ⑥ Цус багадалтын шинжилгээ (гемоглобины агууламж ба эритроцитын шинжилгээ)
- ⑦ Элэгний үйл ажиллагаа (GOT, GPT, γ-GTP-ийн шинжилгээ)
- ⑧ Цусан дахь липидийн түвшин
- ⑨ Цусан дахь сахарын түвшин
- ⑩ Шээсний шинжилгээ (шээсэн дэх сахар, уургийн агууламж)
- ⑪ Электрокардиограммын шинжилгээ

Ажил дээр бэртэж гэмтэх тохиолдлууд

Хөдөө аж ахуйн ажил дээр техникийн дадлагажигчид бэртэж гэмтэх тохиолдлууд

Эцэст нь ажил дээр бэртэж гэмтэх жишээнүүдийг авч үзэх болно. Ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж тус хэсгийн төгсгөл дэх шалгах хуудсыг ашиглана уу.

Жишээ 1

Нэгэн техникийн дадлагажигч комбайнаар ургац хурааж байхдаа комбайнд тээглэсэн үндсийг салгах гээд машины эргэлдэж буй эд ангид хуруугаа татуулж гэмтсэн тохиолдол.



Ослоос урьдчилан сэргийлэх

Үндэс өвс гэх мэт тээглэсэн зүйлийг салгахдаа машиныг үргэлж зогсоож байхыг техникийн дадлагажигчдад урьдчилан зааж өгөх. Хэрэв машин нь хурц ирмэгтэй эд ангитай бол үүнд хүрэхдээ зүсэгдэлтээс хамгаалах бээлий өмсөж зориулалтын багаж хэрэгсэл ашигла.


Жишээ 2

Сонгино ялгаж байсан техникийн дадлагажигч эргэлдэж байгаа өнхрүүш дээр унасан ишийг авах гээд бээлийгээ өнхрүүшт тээглүүлж гараа гэмтээсэн тохиолдол.

Ослоос урьдчилан сэргийлэх

Тухайн хийж буй ажлын төрлөөс шалтгаалан бээлий өмсөж ажиллах нь тээглэх эрсдэлтэй байдаг. Тиймээс хэрэгжүүлэгч байгууллагууд тухайн ажил даалгаварт бээлий өмсөх шаардлагатай эсэхийг урьдчилан тодорхойлж тусгай зааварчилгаа өгөх хэрэгтэй.

Унасан зүйлийн овор хэмжээ зэрэг тухайн нөхцөл байдлаас шалтгаалан унасан зүйлийг авах, салгахын өмнө машиныг унтраах шаардлагатай байж болно.



Жишээ 3

Байцааны үр суулгаж байсан техникийн дадлагажигч машины гинж ба дугуй хооронд тээглэсэн чулууг салгах гээд бээлийгээ тээглүүлж баруун гарынхаа хуруунуудыг гэмтээсэн тохиолдол.

Жишээ 4

Хуурай мод тээрэмдэж байсан техникийн дадлагажигч бутлуурт тээглэсэн хэлтэрхийг салгах гээд эргэлдэж буй ир рүү татагдсаны улмаас зүүн хөлнийх нь хуруунууд гэмтсэн тохиолдол.

Жишээ 5

Техникийн дадлагажигч унтраастай сав баглаа боодлын машиныг цэвэрлэж байгаад асаах унтраалгад санамсаргүй хүрсэн байна. Машин гэнэт асаж дадлагажигчийн баруун гар хөдөлгөөнт эд ангиудад татагдаж бэртсэн тохиолдол.

Жишээ 6

Техникийн дадлагажигч автомат сав баглаа боодлын машин дотор хуйлаастай гялгар уут хийж байтал машин гэнэт асаж баруун гараа хөдөлгөөнт эд ангиудад тээглүүлж гэмтсэн тохиолдол.

Жишээ 7

Мөөг савлах машин ашиглаж байсан техникийн дадлагажигч савлах хальстай холбоотой асуудлыг засах гээд улмаас баруун гар нь машинд хавчигдаж гэмтсэн тохиолдол.

Жишээ 8

Сэрээт өргөгчийн сэрээнд уясан олс ашиглан мод өргөх үед техникийн дадлагажигч өргөх хэсгийн доогуур ган хоолой тавих гэтэл олс нь тасарч, мод унасны улмаас зүүн гарын эрхий хуруу гэмтсэн тохиолдол.

Жишээ 9


Гидравлик хүрэээр хашаа өргөж нүүлгэх үед хашааны орой дээр зогсож байсан техникийн дадлагажигч гидравлик гарын хэсэгт хөлөө хавчуулж гэмтсэн тохиолдол.

Дараах асуултуудад хариулна уу.

1	Аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдагч томилогдсон уу? (Аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөгч гэх мэт*)	☐
2	Машин, тоног төхөөрөмж хамгаалалтын таг, бүрхүүлтэй юу?	☐
3	Машин, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг хангах үзлэг, засвар үйлчилгээг хийсэн үү?	☐
4	Ажиллах орчин цэвэрхэн, эмх цэгцтэй юу?	☐
5	Дадлагажигчид ажлыг аюулгүй хийхийн үүднээс хамгаалалтын хэрэгсэл ашигладаг уу? (Ажлын гутал, тоноглол, бээлий, дуулга, хийн маск, г.м.)	☐
6	Аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт явуулдаг уу? (Ажилд элсүүлэх, эсвэл ажлын төрөл өөрчлөгдөхөд г.м.)	☐
7	Дадлагажигчид ажлын журамтай сайтар танилцсан уу? → Хэрхэн? ☐ Япон хэлээр ☐ Эх хэлээр нь ☐ Өгсөн зааварчилгаа	☐
8	Дадлагажигчдад өгсөн зааварчилгаа болон бусад мэдээллийг ойлгуулж, осол бэртлээс сэргийлэхийн үүднээс япон хэлийг анхан шатны түвшинд зааж, тэмдэг, дохио зангааны талаар мэдлэгтэй болгосон уу?	☐
9	Дадлагажигчдад пайз, тэмдэг зэргийн утгыг аль болох ойлгомжтой байлгахын үүднээс үлгэрлчилсэн зураглал болон бусад арга барицыг ашигладаг уу?	☐
10	Лиценз авах эсвэл ур чадварын сургалтад явахыг шаардсан ажилд мэргэшсэн дадлагажигчдыг оролцуудаг уу?	☐

* Аж үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд зааснаар “10-аас 50 байнгын ажилчинтай ойн аж ахуйн зэрэг компанид аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөхийг томилох”, “50-аас илүү ажилчинтай ойн аж ахуйн зэрэг компанид аюулгүй байдлын менежерийг томилох”-ыг тус тус шаардсан байдаг.

Дээрх шаардлагад газар тариалангийн ажил ороогүй болно. Гэсэн хэдий ч, аюулгүй байдлын арга хэмжээг хөхүүлэн дэмжих үүрэг бүхий Аюулгүй байдлын зөвлөхийг томилж, 5S зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж техникийн дадлагажигчдын аюулгүй байдлыг хангах нь зүйтэй.



Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллага оффис / бүс нутгийн оффис
болон салбар нэгжийн хаяг

Оффисын нэр	Засаг захиргаа	Шуудангийн код	Хаяг	Утас
Төв оффис	—	108-0022	LOOP-X 3F, 3-9-15, Kaigan, Minato-ku, Tokyo	03-6712-1523 (Төв операторын дугаар) 03-3453-8000 (Дуудлагын төв)
Саппоро оффис	Hokkaido	060-0034	Maruito Kita4-jo Bldg. 5F, 2-8-2 Kita4-johigashi, Chuo-ku, Sapporo-shi, Hokkaido	011-596-6445 (Удирдамжийн хэлтэс)
Сендай оффис	Aomori, Iwate, Miyagi, Akita, Yamagata, Fukushima	980-0803	Sendai Fukoku Seimei Bldg. 6F, 1-2-1 Kokubuncho, Aoba-ku, Sendai-shi, Miyagi	022-398-6126 (Удирдамжийн хэлтэс)
Токио оффис	Tochigi, Gunma, Saitama, Chiba, Tokyo, Kanagawa, Yamanashi	101-0041	Urban Center Kanda Sudacho 4F, 2-7-2 Kandasudacho, Chiyoda-ku, Tokyo	03-6433-9971 (Удирдамжийн хэлтэс)
Мито салбар	Ibaraki	310-0062	Asahi Seimei Mito Bldg. 2F, 1-2-40 Omachi, Mito-shi, Ibaraki	029-350-8856 (Удирдамжийн хэлтэс)
Нагано салбар	Niigata, Nagano	380-0825	Nakajima Kaikan Bldg. 6F, 1361 Suehirocho, Minaminagano, Nagano-shi, Nagano	026-217-3556 (Төв операторын дугаар)
Нагояа оффис	Shizuoka, Gifu, Aichi, Mie	460-0008	Nikken/Sumisei Bldg. 5F, 4-15-32 Sakae, Naka-ku, Nagoya-shi, Aichi	052-684-8412 (Удирдамжийн хэлтэс)
Тояама салбар	Toyama, Ishikawa, Fukui	930-0004	Toyama Kogin Bldg. 11F, 5-13 Sakurabashidori, Toyama-shi, Toyama	076-481-7560 (Удирдамжийн хэлтэс)
Осака оффис	Shiga, Kyoto, Osaka, Hyogo, Nara, Wakayama	541-0043	Osaka Asahi Seimei Bldg. 4F, 4-2-16 Koraibashi, Chuo-ku, Osaka-shi, Osaka	06-6210-3722 (Удирдамжийн хэлтэс)
Хирошима оффис	Tottori, Shimane, Okayama, Hiroshima, Yamaguchi	730-0051	Hiroshima Rijodori Bldg. 3F, 3-1-9 Otemachi, Naka-ku, Hiroshima-shi, Hiroshima	082-207-3126 (Удирдамжийн хэлтэс)
Такамацу оффис	Tokushima, Kagawa	760-0023	Takamatsu Kotobukicho Prime Bldg. 7F, 2-2-10 Kotobukicho, Takamatsu-shi, Kagawa	087-802-5850 (Төв операторын дугаар)
Мацуяама салбар	Ehime, Kochi	790-0003	Gibraltar Seimei Matsuyama Bldg. 2F, 7-1-21 Sanbancho, Matsuyama-shi, Ehime	089-909-4110 (Төв операторын дугаар)
Фукуока оффис	Fukuoka, Saga, Nagasaki, Oita, Okinawa	812-0029	Nikkan Kogyo Shinbun Seibu Branch Bldg. 5F, 1-1 Komondomachi, Hakata-ku, Fukuoka-shi, Fukuoka	092-710-4083 (Удирдамжийн хэлтэс)
Кумамото салбар	Kumamoto, Miyazaki, Kagoshima	860-0806	MY Kumamoto Bldg. 8F, 1-7 Hanabatacho, Chuo-ku, Kumamoto-shi, Kumamoto	096-223-6470 (Удирдамжийн хэлтэс)

Техникийн дадлагажигчдын аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээний гарын авлага
<Хөдөө аж ахуйтай холбоотой ажлууд> Монгол хувилбар

2025 оны 3-р сард нийтлэв

Бүтээсэн, нийтэлсэн: Organization for Technical Intern Training
LOOP-X 3F, 3-9-15, Kaigan, Minato-ku, Tokyo, 108-0022
Website <https://www.otit.go.jp/>

Орчуулсан, хянан засварласан: Torindo Co., Ltd.
6F PMO Tamachi, 5-31-17 Shiba, Minato-ku, Tokyo 108-0014
Website <https://torindo.ne.jp>

Тус гарын авлагыг 2024 оны 10-р сард хүчин төгөлдөр байсан хууль тогтоомж дээр үндэслэн нийтлэв.
